




ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ
ҮНДЭСТЭН



ЖИЛИЙН ТАЙЛАН 2023



**ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН
ИЛГЭЭЛТ**

1	ТУЗ-ИЙН ДАРГЫН ИЛГЭЭЛТ
3	ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ИЛГЭЭЛТ

БИДНИЙ ТУХАЙ

9	АЛСЫН ХАРАА
9	ЗОРИЛТ
9	ҮНЭТ ЗҮЙЛС
10	МӨРДӨХ ЗАРЧИМ
10	ДАВУУ ШИНЖ ЧАНАР
11	ЧОНЫН БИЛЭГДЭЛ
13	ТОВЧ ТҮҮХ
21	ХҮНИЙ НӨӨЦ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

25	БАНКНЫ КЛАСТЕР
27	ДААТГАЛЫН КЛАСТЕР
30	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ КЛАСТЕР

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

#БИДИЛҮҮБАЙЖЧАДНА	33
БОЛОВСРОЛ	34
БАЙГАЛ ОРЧИН	35

ЭКОСИСТЕМ

АРД АПП	39
БҮТЭЦ	45
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАГЦ	47

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ	
ЗӨВЛӨЛ	53
УДИРДЛАГЫН БАГ	63
ХУВЬЦААНЫ АРИЛЖАА	66

**АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

ҮНЭЛГЭЭ	67
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	69
ТАЙЛБАР ТОЛЬ	76

Эрхэм хувьцаа эзэмшигчид ээ!

Юуны түрүүнд Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоох эрхэм зорилгын төлөө хамтдаа зүтгэж буй минь том завшаан бөгөөд нэр төрийн хэрэг гэдгээ илэрхийлмээр байна. 10 жилийн өмнө үүсгэн байгуулсан компани маань хөгжлийн дараагийн хуудсаа эргүүлж байна. Энэхүү илгээлтээр шинэ оны мэнд хүргэж, хүндэтгэл үзүүлэхийн зэрэгцээ компанийн 2023 оны эцсээрх нөхцөл байдлыг тоймлон товч мэдээлэл өгөхийг хүслээ.

Эдийн засгийн хувьд хүн бүрд хүнд хэцүү туссан цаг үе өнгөрчээ. Монгол улсын хувьд Ковид 19, хилийн хориг, хөл хорио, нийлүүлэлтийн гинжин хэлхээний саатал, дайнаас үүдэлтэй хориг арга хэмжээ тэргүүтэй олон хямралт хүчин зүйлийн нөлөөгөөр өндөр инфляц бий болж, мөнгөний хатуу бодлого баримтлах болсон нь 2023 оны эцэст шатахууны хомсдол, цахилгааны хязгаарлалт гэх мэт эрчим хүчний хосолсон хямралд хүргэв.

Гэсэн ч эцэст нь Монгол Улс даван гарч чадлаа – эдийн засгийн өсөлт долоон хувьд хүрч, инфляц нэг оронтой тоонд багтаж, олон улсын бондуудын их хэмжээний өр төлбөрийг төлж барагдуулсан мөртөө манай улсын гадаад валютын албан нөөц 4.5 тэрбум доллар буюу бүх цаг үеийн дээд хэмжээндээ дөхжээ. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 5.2 мянган долларт хүрсэн нь хөгжиж буй аль ч улсын хувьд томоохон амжилт. БНХАУ-ын зүгээс эрэлт нэмэгдсэнээс манай улсын экспорт ч өндөр өсөлттэй байна. Засгийн газраас 2024 онд 27 их наяд төгрөгийн төсөв баталсан нь түүхэн дээд үзүүлэлт билээ.

Хэдийгээр бид ирэх зун болох Улсын Их Хурлын сонгуулийг урьдаж бэлтгэлээ базаах шаардлагатай ч эдийн засгийн эерэг орчин бий болно хэмээх найдварыг тээн сууна.

Хоёр жилийн өмнө эхлүүлсэн Ардын стратегийн бүтцийн өөрчлөлтийн үр дүнд компани хоёр хуваагдаж Ард Венчурс бие даасан холдинг компани болох ажиллагаа хийгдсээр байна. Ард Санхүүгийн Нэгдэл Ард Венчурсыг 100 хувь эзэмшдэг хэвээр байгаа боловч Группын бүтцэд байсан санхүүгийн бус компаниудыг Ард Венчурсын харьяанд шилжүүлэхэд шаардлагатай ихэнх ажлыг 2023 онд хийж дуусгалаа.

Та бүхний мэдэж байгаачлан Группын менежментийг 3 кластерт хуваарилсан нь цааш урагшлахад хамгийн үр ашигтай шийдвэр байсан гэдэг нь нотлогдсоор байна. Ардын Тэтгэврийн Данс компанийг дахин хөрөнгөжүүлж, нээлттэй хувьцаат компанийн дор оруулаад байна. Түүнчлэн, 30 жилийн ойгоо тэмдэглэх гэж буй Ард Даатгал 2023 онд 30 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, дээд амжилт тогтоожээ.

Ард Актив өсөлтийн эрчээ хадгалсаар зээлийн багц нь 34 тэрбум төгрөгийн босгыг давлаа. Ард Кредитын нийт зээлийн багц 50 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд зах зээлийн таагүй нөхцөл байдлын улмаас бид 8.9 тэрбум төгрөгийн Нэмэлт хувьцаа гаргаж (FPO) хөрөнгө босгох ажлаа 2024 оны эхний улирал руу хойшлуулахаар шийдвэрлэсэн. Ард Лизингийг дахин хөрөнгөжүүлсэн бөгөөд тус компанийн үйл ажиллагаа 2024 онд сэргэх хүлээлттэй байна.

2024 онд Золбоотой хамтран Хөрөнгө Оруулалтын Банкны кластерт бүтцийн өөрчлөлт хийхээр төлөвлөж байна. Ард Секюритиз нь 2023 онд 40 тэрбум төгрөгийн бонд борлуулсан бөгөөд үүний ихэнх нь Ард Санхүүгийн Нэгдлийн үйл ажиллагааг дахин санхүүжүүлэх зорилготой байлаа. Цаашид хөрөнгийн зах зээл, компанийн судалгаа, хувьцааны андеррайтинг зэрэгт төвлөрөн ажиллах шаардлагатай юм. Мөн бид Ард Менежмент болон түүний удирдаж байгаа хамтын сангуудын үйл ажиллагааг эрчимжүүлэхийг зорьж байна.

Бид КриптоҮндэстэнг Ард Бит, АйДакс, Дайверс Солюшн компаниудтай тусад нь гаргасан. Мөн Телеграм, сошиал медиа платформын TON болон нүүрстөрөгчийн хийг бууруулах дэвшилтэт платформ болох Offsetted компанид тус тус хөрөнгө оруулалт хийжээ. Улаанбаатар Үнэт Цаасны Бирж INQ ETF гэх салбартаа анхдагч биржээр арилжаалагддаг санг бүртгэсэн. Тус сан нь NASDAQ хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй тэргүүлэх компаниудын хувьцаанаас



бүрдсэн бөгөөд дотоод хөрөнгө оруулагчдад бага зардлаар хөрөнгө оруулах боломжийг олгож байна. Түүнчлэн УБҮЦБ нь МОСТ Финтек компанийн анхдагч зах зээлийн арилжааг явуулж, 1,500 гаруй захиалгыг амжилттай биелүүлсэн. Хоёрдогч зах зээлийн арилжаагаар МОСТ Финтекийн нэгж хувьцаа нь 55.7 төгрөгөөр хаагдаж зах зээлийн үнэлгээ нь 27 тэрбум төгрөгт хүрсэн.

АрдКойн 3.0 хувилбараа нэвтрүүлж, хэрэглэгч, хамтрагч байгууллагууд руу чиглэсэн илүү төвлөрсөн бус хэлбэрт шилжсэн. АрдКойн нь Ethereum, Polygon, Binance Smart Chain гэсэн 3 блокчэйныг дамнаж, тэдгээрийн хэрэглэгчдийг холбосон 400 мянга гаруй блокчэйн хаягтай болоод байгаа ба харилгачийн урамшууллыг блокчэйн дээр зардал багатайгаар тараах шийдлийг нэвтрүүлсэн.

Бидний 2023 онд танилцуулсан Ард Аппын V5 хувилбарын хөгжүүлэлтийн ажлууд тасралтгүй хийгдсээр, улам чанартай болсоор байгаа бөгөөд ирэх жил ч сайжруулалтын ажлууд үргэлжлэх төлөвтэй байна. АрдКидс аппад бүртгэлтэй хүүхдийн тоо 50,000 босгыг давлаа. Борлуулалтыг АрдКойноор урамшуулдаг Түмэн Ард гэх олон шаталт маркетингийн хөтөлбөрийг саяхнаас эхлүүлээ. Нийлүүлэлтийн гинжин хэлхээний санхүүжилтийн дижитал шийдэл болох СКОПА төсөл амжилттай хэрэгжсээр байна. Монголын анхны арилжааны сошиал медиа платформ болох mongol.net нээлтээ хийлээ. Эдгээр бүх санаачлагууд нь манай экосистемийн тэлэлтэд сайнаар нөлөөлж, компаниудын борлуулалтыг нэмэгдүүлэх нь дамжиггүй юм.

Сүүлийн нэг жилд хөрөнгийн зах зээл өндөр савлагаатай байлаа. Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцаа 2023 оны 7 сард ёроолдож, IV улиралд сэргэсэн. MSE: AARD хувьцаа өнгөрөгч онд 4,732 төгрөгөөр хаагдаж 2023 онд хамгийн багадаа 3,013 төгрөгт хүрсэн бол сая 2023 онд 3,506 төгрөгөөр хаагдаж, зах зээлийн үнэлгээ 100 тэрбум төгрөгийн босгыг давлаа. Хэдийгээр Ардын компаниуд өнгөрсөн жилийн ханшаасаа өндөр хаалт хийж чадаагүй ч манай хувьцаа өсөх замдаа байгаа гэж бид үзэж байна. Сайн мэдээ нь бидний хувьцаа аль хэдийн ёроолдсон гэж үзвэл дахиад доошоо явах орон зай байхгүй.

Ард Дэлхийн Эдийн Засгийн Форумын дэргэдэх Шинэ Аваргуудын нийгэмлэгт уригдсан бөгөөд бид тэдний Strategic Intelligence онлайн мэдээллийн баазад хувь нэмрээ оруулж, мэдээлэл хуваалцах боломжтой боллоо.

2023 он бидний хувьд олон өөрчлөлтийг дагуулсан жил байлаа: бидэнтэй хамт олон жил ажилласан Батбаяр дарга ажлаа хүлээлгэн өгснөөр миний бие Ард Санхүүгийн Нэгдлийн ТУЗ-ийн Даргын үүргийг хүлээн авч, Б.Золбоог Гүйцэтгэх Захирлын Үүрэг Гүйцэтгэгчээр томилсон юм. Түүний хувьд хэдийгээр нас залуу боловч хамт олон дундаа авьяаслаг манлайлагч гэдгээ тодоор харуулж байгаа бөгөөд, би түүний ажилдаа үнэнч, тууштай байдалд сэтгэл хангалуун байгаа. Мөн ноён Роланд Нэш шинэ ТУЗ-ийн гишүүнээр сонгогдов.

Би одооноос эхлэн Ард Венчурсийн удирдлагад биечлэн оролцох бөгөөд Ард Венчурс нь Улаанбаатар Үнэт Цаасны Бирж, ГрэйпСити Монгол, МОСТ Финтек (UBX: MOST), ТэнГэрЛиг Медиа Нэгдэл (MSE: TNGR), Крипто Үндэстэн (MSE: CNF) зэрэг олон салбарын, бие даасан компаниудыг агуулах юм. Эдгээр нь бүгд тусдаа удирдлагатай, бие даасан стратеги бүхий холдинг компаниуд юм. Бид эдгээр бизнес тус бүрт стратегийн түншүүд болон хөрөнгө оруулагчдыг татах боломжийг судлах бөгөөд Ард Секюритиз энэ ажилд гол үүрэг гүйцэтгэнэ.

Хүндэтгэсэн

Хутагт Овогтой Чулууны Ганхуяг
Ард Санхүүгийн Нэгдэл ХК ТУЗ-ийн Дарга





Эрхэм хувьцаа эзэмшигчид ээ!

Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2022 оны 5 хувиас 2023 онд 7 хувь болж нэмэгдсэнд голчлон уул уурхай болон экспортын эрчимжилт нөлөөллөө. Нүүрсний экспорт жилд хоёр дахин нэмэгдэж, 63 сая гаруй тоннд хүрснээр түүхэн дээд амжилт тогтоосон бөгөөд Оюу толгойн далд уурхайг эхлүүлснээр зэсийн олборлолт 20 орчим хувиар өссөн байна. Гэвч цар тахлын дараах сэргэлт удааширч, цаг уурын таагүй нөхцөл байдал хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд нөлөөлж, уул уурхайн бус салбарууд, тэр дундаа үйлчилгээний салбарын өсөлт удааширлаа.

Хэдийгээр улсын сектор эдийн засгийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэсэн ч хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт буурсан үзүүлэлт гарсан байна. Мөн цалингийн өсөлтийг үл харгалзан хөдөлмөрийн зах зээлийн зогсонги байдал болон өндөр инфляциас үүдэлтэй бодит орлогын элэгдэл нь хувийн хэрэглээнд нөлөөлж, багахан өсөлттэй байв. Уул уурхайн салбарын хурдацтай өсөлттэй холбоотой 2007 оноос хойших хамгийн өндөр төсвийн ашигтай жил болж, улсын нийт өрийн ДНБ-д эзлэх хувь буурлаа. Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж, халамжийн хөтөлбөрт чиглэсэн засгийн газрын зардал өссөн ч гэсэн дээрх амжилтыг үзүүлж чаджээ.

Экспорт эргэж сэргэсэнтэй холбоотойгоор урсгал тэнцэл ашигтай гарч, 2023 оны эцэс гэхэд гадаад валютын нийт нөөц түүхэн дээд хэмжээгээ давж, 4.9 тэрбум долларт хүрчээ. Түүхий эдийн үнэ уналттай байгаа хэдий ч уул уурхайн экспортын өсөлт, Хятадын нүүрсний эрэлт, Оюутолгойн зэсийн экспорт нэмэгдсэн нь тус сөрөг нөлөөллийг бууруулахад тусалсан. Гэсэн хэдий ч гадаад валютын нөөц нь 4.4 сарын импортын хэрэглээтэй тэнцэж байна.

Инфляцын түвшин өндөр хэвээр байгаа ч оны турш буурсаар, 2022 онд 13.2 хувь байсан инфляц 2023 оны эцэст 7.9 хувьд хүрээд байна. Инфляц буурч байгаа нь нийлүүлэлтийн хүндрэл багассан, тээврийн зардал буурсан, дэлхийн эрчим хүч, хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт саармагжсан, валютын нэрлэсэн ханш тогтвортой байсан зэргээс шалтгаалсан байна. Төсвийн бодлогоор дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авч байгаа хэдий ч Төв банк эрэлтээс үүдэлтэй болзошгүй инфляцын дарамтыг арилгахад чиглэн бодлогын хүүгээ 13 хувьд барих шаардлагатай болсон нь сүүлийн зургаан жилийн хамгийн өндөр хүү болж байна.

Банкууд илүү найдвартай зээлийг чухалчилж, бизнесийн болон ипотекийн зээлийг хязгаарласантай холбоотой зээл олголт багатай байв. Цалин, тэтгэвэр, хадгаламжаар баталгаажсан зээлүүд нийт зээл олголтын өсөлтөд голчлон нөлөөлсөн бол аж ахуйн нэгжийн зээлийн өсөлт удаашралтай хэвээр байгаа нь хөнгөлөлттэй зээл олгохгүй байж, эрсдэлээс зайлсхийх хандлагатай холбоотой.

Монголын хөрөнгийн зах зээл хэд хэдэн түүхэн амжилтыг гаргалаа. Зах зээлийн нийт үнэлгээ 10 их наяд төгрөгийг давсан ба үүний гол шалтгаан нь системийн арилжааны банкууд хувьцаагаа олон нийтэд гаргасан явдал байв. Мөн биржээр дамжуулан нүүрс арилжаалдаг болсноор нийт 7.7 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан нь түүхэн дээд үзүүлэлт боллоо. Гэвч оны турш зах зээл савалгаатай байж, МХБ-ийн ТОП-20 индекс 20 гаруй хувиар хэлбэлзэж, эцэст нь өнгөрөгч жилтэй харьцуулахад 10 хувийн өсөлт үзүүлээ.

2024 онд хувийн секторын хэрэглээний өсөлт болон төсвийн тэлэлт нь эдийн засгийн өсөлтийг жолоодох төлөвтэй байна. Засгийн газар ирэх хоёр жилийн бондын өглөгөө дахин санхүүжүүлж, гадаад валютын нөөцийн тогтвортой байдлыг хангалаа. Уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдэж, 2023 онд буураад байсан хөдөө аж ахуйн үйлдвэрлэл сэргэнэ гэж төсөөлж байна. Хувийн секторын хэрэглээ сэргэж байгаа тул үйлчилгээний салбар динамик хэвээр байх төлөвтэй байна. Эрэлтээс шалтгаалсан инфляцын өсөлт хүлээгдэж буй хэдий ч мөнгөний хатуу бодлого баримталж, нийт инфляц буурч 2024 оны туршид Монголбанкны зорилтот хэмжээ болох $6 \pm 2\%$ дотор байх таамагтай байна. Үүнтэй холбоотойгоор мөнгөний бодлого суларч, бодлогын хүү буурч эхлэх хүлээлттэй байна.

Гэвч 2024 онд төсвийн тэлэлт орлогын өсөлтөөс давна гэж таамаглаж буйтай холбоотойгоор төсөв алдагдалтай гарахаар байна. Дэлхийн хэмжээнд санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал амаргүй байхаар төсөөлөгдөж буйгаас шалтгаалан экспортын орлого энгийн түвшин рүүгээ буурах, импорт нэмэгдэх, хөрөнгийн урсгал хязгаарлагдмал байдалтай байх хандлагатай байгаа бөгөөд энэ нь 2024 онд төлбөрийн тэнцэлд дарамт үзүүлэхээр байна.

Олон сөрөг нөлөөтэй эрсдэлүүд байгаа ч мега төслүүд боломж дагуулж байна. Хятадын эдийн засгийн өсөлт таамаглаж байснаас удаашралтай байгаа нь Монголын эдийн засаг, ялангуяа нүүрсний экспортод сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм. Сонгуулийн өмнөх нөхцөл байдалд төсвийн зардал төсөөлж байснаас илүү тэлсэн нь инфляцын дарамт, урсгал тэнцэл, төсвийн алдагдлыг нэмэгдүүлэхэд хүргэх магадлалтай.

Ойрхи Дорнод дахь геополитикийн хурцадмал байдал нефтийн үнийг өсгөж, гадаад тэнцэл болон дотоодын шатахууны үнэд сөргөөр нөлөөлөх боломжтой. Эсрэгээр, Орано ураны төслийг хэрэгжүүлэх, Оюутолгойн далд уурхайн олборлолтыг нэмэгдүүлэх зэргээр мега төслүүдийг эрчимтэй дуусгах нь уул уурхайн экспорт хүлээлтээс давж гарахад туслах юм.

2023 онд Нэгдлийн хэмжээнд хөрөнгө, өрийн удирдлага, бүтцийн өөрчлөлт, оновчлолд голчлон анхаарч, дараагийн гурван жилдээ баримтлах OGSM-ээ тодорхойлсон. Шинэ OGSM нь бидэнд салбартаа түйвээлт хийж, инновацаар манлайлах, үйл ажиллагаа болон санхүүгийн гүйцэтгэлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн цогц бүтээгдэхүүн үйлчилгээг агуулсан дижитал маркетинг бүтээх замаар Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоох бололцоог олгох юм. Энэхүү батлагдсан OGSM-ийн дагуу Нэгдлийн бизнес төлөвлөгөөг гарган үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн.

Бүтцийн өөрчлөлт нь бидний чиглэлийг илүү тодорхой болгож өгөхөөс гадна хууль эрх зүйн болон үйл ажиллагааны хувьд ашиг сонирхлын зөрчлийг бууруулж, бизнесийн харилцааг жигдрүүлэхэд тусалж байна. Бүтцийн өөрчлөлтийн хүрээнд нийтдээ 50 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгийн шилжилтийг хийлээ.

- Холдинг компанийн хөрөнгө оруулалтын багцад бүтцийн өөрчлөлт хийж, санхүүгийн бус чиглэлийн компаниудыг тусад нь гаргаж, Хөвсгөл ХК-ийн дор шилжүүлсэн. Үүний хүрээнд Крипто Үндэстэн, ГрэйпСити Монгол, Даац Инвестмент (УБҮЦБ-ийн толгой компани), Гэр Интерьер Дизайн зэрэг компаниудыг нийт 15 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий хувьцаанд хөрвөх боломжтой өр хэлбэрээр шилжүүлсэн.
- Мөн Ард Санхүүгийн Нэгдэл нь Ардын Тэтгэврийн Данс болон Монгол Шуудан, ТэнГэрЛиг Медиа Нэгдэл дэх эзэмшлийнхээ тодорхой хэсгийг буюу нийт 25 тэрбум төгрөгийн хөрөнгөө Хөрөнгийн биржид бүртгэлтэй компани болох Өндөрхаан ХК-д шилжүүллээ.
- Ард Лизинг компанийг 18 тэрбум төгрөгөөр хөрөнгөжүүлсэн.

Үүнээс гадна манай хөрөнгө оруулалтын багц дахь компаниуд борлуулалтаа нэмэгдүүлэх, өсөлт гаргах тал дээр шаргуу ажиллаж, туйлын сайн үр дүнг харууллаа.

- Ард Кредитын нийт хөрөнгө 72 тэрбум төгрөгт хүрч, 23 хувиар өссөн бол цэвэр зээлийн багц нь 48 тэрбум төгрөг буюу жилийн өмнөхөөс 8 орчим тэрбум төгрөгөөр өслөө. Тэд 2023 онд барьцаат зээл гаргах тал дээр анхааран ажилласан ба жилийн хугацаанд нийт 7.7 тэрбум төгрөгийн автомашины зээлийг амжилттай санхүүжүүллээ. СЗХ-ноос нэмэлт хувьцаа гаргах саналыг нь зөвшөөрч, нийт хувьцааныхаа 30 хувьтай тэнцэх нэмэлт хувьцааг гарган 8.9 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгө босгох боломж нээгдсэнээр 2024 оны эхний улиралд амжилттай хэрэгжүүллээ. Ингэснээр Ард Кредит нь нэмж 36 тэрбум төгрөгийн эх үүсвэр татах боломжтой боллоо.
- Ард Актив 2023 онд нийт хөрөнгөө 40 хувиар өсгөж, 44 тэрбум төгрөгт хүргэсэн. Хадгаламж зээлийн хоршоо нь гишүүдээ органик байдлаар тогтмол нэмэгдүүлж 4,053 гишүүнтэй болжээ. Байгууллагын үр ашигтай бүтэцтэй тус компани сүүлийн жилүүдэд тогтвортой ашиг олж, сайн багцын чанартай буюу хугацаа хэтэрсэн зээлийн түвшинг нэг хувьд барьж байна.
- Ард Лизинг нь 2024 онд Өсдөг Машин хөтөлбөр дээрээ түшиглэн лизингийн үйл ажиллагаагаа сэргээхээр төлөвлөж байна
- Байгалийн гамшиг, инфляцийн улмаас нөхөн төлбөрийн хүсэлт нэмэгдэж, даатгалын салбарт хүндрэл бэрхшээлүүд тулгарсан хэдий ч Ард Даатгал 2023 онд маш сайн ажиллаа. 25 тэрбум төгрөгийн жилийн борлуулалтын төлөвлөгөөгөө давуулан биелүүлж 32.5 тэрбум төгрөгийн борлуулалт хийснээр түүхэн дээд амжилт гаргалаа. Нөхөн төлбөр өндөр байсантай хэдий ч цэвэр ашгийн хэмжээ 3.3 тэрбум төгрөгт хүрэв. Компанийн хөрөнгө 24 хувиар өсч, 44.2 тэрбум төгрөгт хүрсэн ба үүнээс 19.1 тэрбум нь тогтмол өгөөжтэй хөрөнгө, 4.8 тэрбум нь хувьцаа, 4.1 тэрбум нь бусад төрлийн хөрөнгө байлаа.
- Ардын Тэтгэврийн Данс компани 2023 онд сард татдаг тэтгэврийн хуримтлалаа 300 сая төгрөгөөс 800 сая төгрөг болгон нэмэгдүүлж чадсан ба байгууллагын борлуулалтаа өсгөхөд голчлон анхаарлаа. Зах зээлийн уналт компанийн хөрөнгө оруулалтын багцад нөлөөлж байгаа хэдий ч тэд багцаа илүү оновчтой болгохоор шамдан ажилласан. Үүний хүрээнд багц дахь тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүнээ нэмэгдүүлэх ажил хийгдсэн. 2024 онд тус компани хөрөнгө оруулалтын багцын оновчлолоо үргэлжлүүлэхийн зэрэгцээ хараахан батлагдаагүй байгаа Хувийн тэтгэврийн тухай хуульд үйл ажиллагаагаа нийцүүлсэн байдлаар урьдчилан бэлтгэж ажиллахыг зорьж байна
- 2023 онд Ард Секюритиз нь Нэгдлийн хөрөнгийн зах зээлтэй холбоотой ажилд голчлон оролцож, үнэт цаасны андеррайтингийн үйл ажиллагааг манлайлах үүрэг гүйцэтгэлээ. Тус компани МОСТ Финтек компанийн IPO-ийн анхдагч зах зээлийн арилжааг амжилттай гүйцэтгэж, тухайн компанийн 27 хувийг олон нийтэд санал болгож 5.7 тэрбум төгрөгийг 1,500 гаруй хувьцаа эзэмшигчдээс амжилттай татсан.

- Ард Менежмент нь Үндэсний Хувьчлалын Сан, Хөрөнгө Оруулагч Үндэстэн Сан гэх хоёр хамтын сангаа удирдаж байна. Хэдийгээр удирдлагад буй хөрөнгийн өсөлт, нэгж эрхийн борлуулалт нь зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалж төлөвлөгөөнөөс бага байгаа ч компани сангуудын хөрөнгийн өгөөжийг тогтвортой байлгах арга хэмжээ авсан. Ард Менежмент 2024 онд жижиглэнгийн хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалт хийхэд хамгийн хүртээмжтэй сангуудыг үргэлжлүүлэн байгуулахаар зорьж байна.
- Ард Пропертиз компани нь өндөр зэрэглэлийн үл хөдлөх хөрөнгийг токенжуулах шинэлэг төслөө Блю Скай Тауэрын 9 давхраар амжилттай хэрэгжүүлж байна. Тухайн үл хөдлөх хөрөнгийг авах төлбөрөө шийдэж, түрээслэхэд бэлэн болгон сэргээн засварласны дараагаар 5 жилийн хугацаатайгаар түрээслүүлж, токен эзэмшигчдэдээ 7 сараас эхлэн тогтмол түрээсийн орлого хуваарилсан. Цаашид компани үл хөдлөх хөрөнгийн менежмент, брокерын зөвшөөрлөө ашиглан үйл ажиллагаа явуулах болно.

Уламжлалт аргачлалаар багц дахь компаниудаа өргөжүүлж, өсгөхийн зэрэгцээ бид дижитал экосистемээ ажаил аргачлалын дагуу идэвхтэй хөгжүүлж байна.

- Манай баг МОСТ, ГрэйпСити компаниудтай хамтран Ард Аппын шинэ хувилбарыг амжилттай нэвтрүүлж, алдаа, асуудлуудыг шийдвэрлэснээр аппын V5 хувилбар руу бүрэн шилжиж, V4 хувилбарыг зогсоолоо. Одоогоор аппын өдөр тутмын хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор хэрэглэгчийн сэтгэгдэл, интерфэйсыг сайжруулах, санхүүгийн үйлчилгээ авах үйл явцыг оновчтой болгох, бусад платформ, системүүдтэй интеграцчилалаа өргөжүүлэх ажлуудыг эрчимтэй хийж байна.
- Бид төлбөрийн шийдэл, урамшууллын системээ ашиглуулах зорилгоор олон төрлийн мерчант байгууллагуудыг бүртгэх ажлыг эхлүүлсэн. Энэ ажлаараа дамжуулан хэрэглэгчдийг манай аппаар өдөр тутмын худалдан авалтаа хийж, Ардкойныг урамшууллын оноо байдлаар цуглуулахыг идэвхжүүлж байна.
- Ард Аппын борлуулалт, хэрэглээг илүү өргөн хүрээнд нэмэгдүүлэх зорилго бүхий Түмэн Ард хөтөлбөрийг нэвтрүүлээд байгаа бөгөөд одоогоор 5,000 гаруй идэвхтэй Ардын Брокер бүртгүүлээд байна. Энэ нь манай экосистемээр санхүүгээ удирдахад өөрийгөө болон бусдыг уриалж буй хэрэглэгчдийг гарсан үр дүнд нь суурилан урамшуулдаг хөтөлбөр юм.

Мөн бид нийт хэрэглэгчдийг автоматжуулсан тэтгэврийн хуримтлал, хөрөнгө оруулалтад хамруулж, хувийн санхүүгээ аппаараа удирддаг болгохоор зорин ажиллаж байна.

Ард Санхүүгийн Нэгдэл нь 2024 онд хоёр жилийн хугацаатай бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийнхөө сүүлийн үе шатыг хэрэгжүүлж, холбоотой компаниудынхаа санхүүгийн эрүүл байдал, гүйцэтгэлийг сайжруулах дээр анхааран ажиллах бөгөөд сүүлийн 10 жилийн хугацаанд бүрдүүлсэн хувьцаа эзэмшигч, харилцагчийн суурь болон экосистемээ төгөлдөршүүлсэнээр бизнесийн тэлэлт, өргөжилт хийх хүлээлттэй байна.



БИДНИЙ ТУХАЙ

Эрхэм зорилго

Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлооно

Алсын хараа

Бүтээлч түйвээлтээр дэлхийд манлайлагч финтек нэгдэл болно

Зорилт

- Бүтээлч түйвээлт
- Дижитал маркетплейс
- Тогтвортой өсөлт

Үнэт Зүйлс


- Бид нэг зорилготой, түүндээ хүрэх зоригтой, зогсолтгүй багуудын хамтрал
- Бидний соёл “Мөс Хагалагч” буюу шинийг санаачлах, хэцүүг шийдэх эрмэлзэл
- Бидний зарчим хэлсэн бол хийнэ, эхэлсэн бол дуусгах хариуцлага
- Бидний давуу тал салбартаа ямагт тэргүүлэгч байх тасралтгүй суралцагч мэргэжлийн баг
- Бидний уриа “Хүчтэй. Хамтдаа” буюу ганцаараа хурдан явах бус хамтдаа холыг зорих

Мөрдөх зарчим

- Ёс зүйн хэм хэмжээг өндөрт тогтоон дагаж, хууль тогтоомжийг чандлан мөрдөхийн зэрэгцээ хүйсийн тэнцвэртэй байдлыг хангаж ажиллана;
- Харилцагчийн үйлчилгээг дээд зэрэгт барих бодлогыг чандлан мөрдөнө;
- Нийгмийн хариуцлага өндөртэй, нийгэмд эерэг өөрчлөлтийг түүчээлж ажиллана;
- Хууль эрх зүйн болон бизнесийн орчиндоо шаардагдаж буй өөрчлөлтүүдийг бий болгохын төлөө санаачилга гаргаж ажиллана;
- Байгаль орчин, эх дэлхийгээ хайрлан хамгаалах шилдэг стандартыг нэвтрүүлж ажиллана

Давуу шинж чанар

- Өрсөлдөх чадвар, үр ашиг болон дэвшилтэт технологийг цогцлуулсан түншлэл
- Амжилттай хөрөнгө оруулалтын туршлага, ил тод засаглал
- Шинэ санаа, төслийг хэрэгжүүлэгч олон улсад танигдсан хамт олон
- Хөрөнгө оруулалтын тогтвортой өгөөж
- Зах зээлийн боломжийг хөрөнгийн үнэ цэн болгох туршлага
- Хөрөнгө оруулагч үндэстний танигдсан брэнд
- Үндэсний хэмжээний цогц дэд бүтэц
- Энтрепренёр соёл



Чонын билэгдэл

Бөртэ чоно, Гуа маралын удамт, хөх толбот Монголчуудын сүр хүч, хийморь сүлдний бэлгэ тэмдэг. Хамгийн гэр бүлсэг, өөрийн сүрэгт насан туршдаа үнэнч байж, тэднийгээ хамгаалж явдаг онцлогтой эл амьтнаар Монгол эр хүний эрэмгий чанарыг дүйцүүлэн дүрсэлжээ.


Эх чоно

Сүргийн тэргүүний нөмөр түшгийг бараадан амьдардаг эмэгчний ёсыг сэвээнд нь наалдан яваагаар илэрхийлжээ.





Үр төл

Амьтан бүхэн үр төлийнхөө төлөө зүрх сэтгэлээ өгч, тэмцэж амьдардгийг эцэг эхийнхээ зүрхэн тушаа хярсан бяцхан бэлтрэгийн дүрээр харуулжээ



Эцэг чоно

Сүргийн манлай эцэг чоно эмэгчнээ нуруундаа үүрч, үр төлөө зүрхэндээ тээж яваагаар дүрсэлжээ.



Товч түүх



Анх 2000 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар болон АНУ-ын Мэрс Кор төрийн бус байгууллага ХасБанкны нийт ажиллагсад зориулан тэдэнд хувьцаа эзэмшүүлэх санд 600 сая төгрөгийг хандивлахаар шийдвэрлэсэн түүхтэй. 2005 онд ХасБанкны ажиллагсад тус сангаас олгогдсон хувьцааны үнэ цэнийг өсгөх, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх зорилгоор өөрсдийн хувьцаагаа нийлүүлж Employee Investment Trust буюу И Ай Ти ХХК-ийг хамтдаа үүсгэн байгуулж ХасБанкны толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн тодорхой хувийг авснаар Монголын анхны институционал хөрөнгө оруулагчийн суурь тавигдсан юм.

И Ай Ти нь үүсгэн байгуулагдах үедээ нийт 1.2 сая төгрөгийн дүрмийн сан, 10 хувьцаа эзэмшигчтэй байсан бол 2022 оны жилийн эцсээр Ард Санхүүгийн Нэгдлийн хэмжээнд нийт 100 мянга гаруй (давхардсан тоогоор) хувьцаа эзэмшигчидтэй болсноос гадна 450 тэрбум орчим төгрөгийн хөрөнгийг удирдаж байна.

Хүн бүр бүтээсэн баялгаасаа хувь хүртэх, харилцагч иргэн бүр үйлчлүүлдэг банкныхаа эзэн нь байх ёстой гэсэн итгэл үнэмшилдээ бид хөтөлгөн 2015 онд Ард Санхүүгийн Нэгдлийг хаалттай хувьцаат компани болгосон билээ. 2017 оны төгсгөлд Хөрөнгө Оруулагч Үндэстэн нь Жинст-Увс нээлттэй ХК тай урвуу хэлбэрээр нэгдэж, Монголын Хөрөнгийн Бирж дээр арилжаалагдаж эхэлсэн бол 2019 оны 8 сарын 8-нд Ард Санхүүгийн Нэгдэл нь урвуу нэгдэл хийснээр нээлттэй хувьцаат компани болсон юм.

2013 онд И Ай Ти-гийн гол хувьцаа эзэмшигчид шинэ стратегийн зорилгоо тодорхойлж, Ард Санхүүгийн Нэгдэл гэх нэрийн дор үйл ажиллагаагаа явуулах түүхэн шийдвэрийг гаргасан. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд банк бус санхүүгийн байгууллага, даатгал, үнэт цаасны компани, тэтгэврийн сан, хадгаламж зээлийн хоршоо зэрэг санхүүгийн байгууллагуудад тасралтгүй хөрөнгө оруулж, нэгдэх, нийлэх ажлыг явуулж, 2016 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр болсон томоохон хувьчлалд амжилттай оролцож Монгол Шуудан ХК-ийн гол хөрөнгө оруулагч болж чадсан юм.


2017 онд үндсэн хөрөнгө оруулалтын багцад хөрөнгө оруулалтын менежментийн компани, блокчэйн болон криптовалютын чиглэлээр ажиллах Ард Бит компани, Крипто Үндэстэн Сан нэмэгдсэн бол 2018-2019 онд технологи, үл хөдлөх хөрөнгө, онлайн худалдаа, харилцагчийн үйлчилгээ, хөрөнгө оруулалт, лизингийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах компаниуд байгуулагдаж, Нэгдлийн бүтцэд багтаж эхлэв.

2020 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр арилжаалагдах анхны хамтын хөрөнгө оруулалтын сан болох Үндэсний Хувьчлалын Санг байгуулсан. Харин криптовалютын сангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Крипто Үндэстэн ХХК нь Булган Ундрага ХК-тай урвуу нэгдэл хийснээс гадна виртуал хөрөнгийн бирж болох DAX-ыг үүсгэн байгуулж, бүтцээ өргөжүүлэв.

2021 онд ТэнГэрЛиг Медиа Нэгдэл ХК, Улаанбаатарын Үнэт Цаасны Бирж хаалттай ХК-иудад хөрөнгө оруулж, МОСТ Финтек ХХК, Грэйп Сити Монгол ХХК-иудтай дараагийн шатны хамтын ажиллагааг эхлүүлсэн юм. Мөн ХАСҮ санг үүсгэн байгуулсан ба Төвлөрсөн бус санхүүгийн зах зээлийн бүтээгдэхүүн болох АрдМааний төслийг эхлүүлэв.

2022 онд Ард Санхүүгийн Нэгдлийн хөрөнгө оруулалтын багцад нийт 46 тусгай зөвшөөрөлтэй 44 компани багтаж байгаа ба тэдгээрийн талаар тус тайлангийн хөрөнгө оруулалт хэсгээс танилцаж болно.

2023 оны Монгол Улсын 0-18 насны хүүхэд бүрт MSE:AARD хувьцаа болон ардкөйн эзэмшүүлэх #БидИлүүБайжЧадна хөдөлгөөнийг эхлүүлэв



Товч түүх

Ард Даатгал, Ард Кредитэд хөрөнгө оруулав **2013**

2014 Ард Актив ХЗХ-д хөрөнгө оруулав

Ард Санхүүгийн Нэгдэл
хаалттай Хувьцаат компани боллоо.
Хөрөнгө Оруулагч Үндэстэн хөдөлгөөнийг эхлүүлэв. **2015**

2016 Монгол Шуудан ХК-ийн хувьчлалд оролцов

Монголын анхны криптовалютын сан
байгуулах анхны хурлаа хийж,
Крипто Үндэстэн байгуулагдав. **2017**

2018 Ард Даатгал IPO хийв

Ард Кредит IPO,
Блокчэйнд суурилсан
(Ардкойн) урамшууллын оноог нэвтрүүлэв **2019**

2020 Аппрентис Монгол ТВ шоууг хийж,
Анхны хаалттай хамтын санг байгуулав

ТэнГэрЛиг Медиа Нэгдэл байгуулагдав (RTO) **2021**

2022 Анхны нээлттэй хамтын санг байгуулав

Монгол Улсын 0-18 насны хүүхэд бүрт
MSE:AARD хувьцаа болон ардкойн эзэмшүүлэх
#БидИлүүБайжЧадна хөдөлгөөнийг эхлүүлэв **2023**

2013

2023



Ард Санхүүгийн Нэгдэл болов

Цогц дижитал банкны үйлчилгээ **1,104,180** хэрэглэгч

10

Хөрөнгө оруулалтын багц
(компани)

44

₮10 тэрбум

Хөрөнгийн удирдлага

₮204 тэрбум

370

Хувьцаа эзэмшигч

+110,000

₮6.4

Нэгж хувьцааны үнэ

₮3,506

Нэгтгэсэн тоон үзүүлэлт



44

Нийт компани

1,104,180

Ард Апп хэрэглэгч

46

Тусгай зөвшөөрөл

418,006

АрдКойн эзэмшигч

264

Нийт ажиллагсад

243,010

Даатгуулагч (идэвхтэй)

4,053

Ард Актив ХЗХ-ны гишүүн

154,496

Үнэт цаасны данс эзэмшигч

20,750

Зээлийн данс (идэвхтэй)

146,749

Тэтгэврийн хуримтлал эзэмшигч

52,515

Нийт ажиллагсад

113,895

Хувьцаа эзэмшигч

ARD САНХҮҮГИЙН
НЭГДЭЛ



Хүчтэй. Хамтдаа.

Хүний нөөц



2023 онд Ард Санхүүгийн Нэгдлийн хэмжээнд Гүйцэтгэх удирдлага, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт хийгдэж удирдлагын багийн 22 хувь өөрчлөгдөж, нийт 264 үндсэн ажилтан байна. Хүний нөөцийн бодлогын хүрээнд ажилтан төвтэй, нээлттэй байдал, оролцоог илүү хүртээмжтэй болгох зорилгоор улирал тутам нэгдсэн судалгаа асуумжийг сэдэвчилсэн байдлаар зохион байгуулсан бөгөөд шинэчлэлт өөрчлөлтийн цаг үетэй нийцүүлэн бидний суурь зарчим Үнэт Зүйлсээ эргэн харах, шинэчлэн сэргээхээр нийт ажилтнуудын оролцоотойгоор шинэчлэн томьёолсныг онцолж байна. Энэ нь бидний үнэ цэн, чухалчлах зүйлсийг дахин тодорхойлж, итгэл үнэмшил зорилгыг нэгтгэж аливаа шийдвэр гаргах мөн чанар, чиг баримжааг олгох чухал ач холбогдолтой билээ.

- Бидний үнэлшгүй хөрөнгө баг хамт олон буюу - ХҮН капитал. Тиймээс нэгж, хэсэг бүлгийн онцлог, шинж чанар ялгаатай байдлыг харгалзан буюу хүйсийн (61 хувь эмэгтэй, 39 хувь эрэгтэй), насны (дундаж нас 34) болон үе хоорондын (62 хувь нь Миллениал, Z Ye) ажиллах арга барилд анхааран хувь хүний үнэ цэн, оролцоог хангах, тасралтгүй суралцах, хөгжих орчныг дэмжин дотоод/гадаад сургалт хөгжлийн хөтөлбөрүүдийг зохион байгуулснаас “Бид Хамтдаа Илүү Хөгжине” уриан дор 3 сарын хугацаанд үргэлжилсэн Ард- Менторшип хөтөлбөрт оролцогчдын 33 хувь нь ахлах/удирдлагын түвшинд албан тушаал дэвшин ажиллах болов.
- Хүний нөөцийн бүрдүүлэлт төдийгүй байгууллагын зах зээлд эзлэх байр суурь нэр хүндийг илэрхийлэх ажил олгогчийн брэнд, танигдалтайд хүний нөөцийн бодлого, өрсөлдөх чадвар, онцгойрох зүйлээ бид олон нийтэд таниулан сурталчлах ажлын хүрээнд их дээд сургууль, ЕБС -ийн нийт 100 гаруй оюутан, сурагчдыг ажлын байрандаа хүлээн авч танилцах хөтөлбөр болон ажлын байрны чиг баримжаа олгох дадлагажигчаар ажиллах боломжийг нээлттэй олгодог. Уг ажлын үр дүнг хэмжих нэгэн үзүүлэлт болох Монголын шилдэг 8 их сургуулийн 500 гаруй оюутнуудын дунд хийсэн судалгаагаар төгсөөд ажиллахыг хүсэж буй ТОП 20 компанийн нэгээр Ард Санхүүгийн Нэгдэл ХК шалгарсан билээ.

Ирэх 3 жилд бизнес үйл ажиллагааны хурдацтай хөгжил дэвшил, өөрчлөлтийг баг бүрэлдэхүүний ур чадвар, арга барил, шинж чанарт тулгуурлан оролцоо энгэйжментийг өндөрт байлгах, гүйцэтгэл-чадамжид суурилсан үндсэн цалин хангамжийн багцаа улам сайжруулах буюу олон төрөл хэлбэрээр төрөлжүүлэх, тухайлбал байгууллагынхаа хувьцааг ажилтнууддаа эзэмшүүлэх хөтөлбөрийг анхлан хэрэгжүүлэгчийнхээ хувьд сайн туршлагаа улам өнгөлөн зах зээлд компанийнхаа ялгарал, давуу тал болгон хөгжүүлэхийг зорьж ажиллана.

Харилцагчийн үйлчилгээ

Ард Санхүүгийн Нэгдэл болон түүний охин компаниудын харилцагчийн үйлчилгээг хариуцдаг Ард Суппорт ХХК нь 2023 онд нийт 435,588 харилцагчид 6 сувгаар үйлчилгээ үзүүлсэн ба лавлах утасны шугамаар 217,564 харилцагчид үйлчилгээ үзүүлж зорилтот үр дүнг 99 хувь хангах ажиллав. Дэлгэрэнгүй тоон үзүүлэлтээс дурдвал:

Үзүүлэлт	Харилцагч хандсан тоо	Асуудал шийдвэрлэлтийн хувь
Нийт үйлчилгээ үзүүлсэн харилцагч	435,588	99%
Цахим сувгаар хүргэсэн мэдээлэл	79,893	100%
Бүх сувгаар бүртгэгдсэн гомдол	22,877	98%
Салбарын үйлчилгээ	11,630	100%
Оператортой холбогдож мэдээлэл авсан	217,564	99%
Автомат хариулагчаас мэдээлэл авсан	23,521	100%
Чатботоос лавлагаа, үйлчилгээ авсан	16,473	100%
Гадагшаа залгаж мэдээлэл хүргэсэн	86,507	92%



ГҮЙЦЭЭТГЭЭЛИЙН ТАЙЛАН



Банкны кластер

Ард Кредит, Ард Актив, Ард Лизинг компаниудаас бүрдсэн Ард Санхүүгийн Нэгдлийн Банкны кластер нь 2023 онд өндөр өсөлт үзүүлж, стратегийн чухал амжилтуудад хүрлээ. Ард Кредит ХК нь нэмэлт хувьцаа гаргах, аутсорсингийн үйлчилгээ авах стратегийн хувьд ач холбогдолтой зөвшөөрлүүдийг зохицуулагч байгууллагуудаас авч, зах зээл дэх байр сууриа улам бэхжүүлсэн.

Phygital аргачлалын дагуу автомашины зээлийн багцаа өргөжүүлснээр барьцаат зээлийн багцаа хоёр дахин нэмэгдүүлж чадсан. Энэхүү өсөлт, санхүүгийн зөв менежментийн үр дүнд 2.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, зах зээлийн үнэлгээ нь 34 тэрбум төгрөг болсон байна.

Ард Актив ХЗХ нь нийт хөрөнгийн хэмжээгээ мэдэгдэхүйц нэмэгдүүлж 44 тэрбум төгрөгт хүргэснээр салбартаа II баяр сууриа хадгалж чадлаа. 34.7 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн багц, 32.9 тэрбум төгрөгийн санхүүжилттэй Ард Актив нь эрсдэлийн ухаалаг менежментийг тууштай хэрэгжүүлснээр зээлийн багцаа маш эрүүл байлгаж чадаж байна. Ард Лизинг компани нь Өсдөг Машин хөтөлбөрөө дахин сэргээх судалгааны ажлуудаа дуусгалаа. Санхүүгийн тогтвортой байдал, стратегийн өсөлтийг чухалчилдаг Банкны кластер нь цаашид өндөр өсөлт үзүүлэхэд чухал үе шатан дээрээ ирээд байна.

Ард Кредит

Ард Кредит ББСБ нь өнгөрсөн онд Санхүүгийн Зохицуулах Хорооноос 8.9 тэрбум төгрөгийн нэмэлт хувьцаа гаргах зөвшөөрөл авсанаас гадна, Монголбанкнаас аутсорсингийн үйлчилгээ авах тусгай зөвшөөрөл авсан 3 дахь байгууллага боллоо. Мөн 2023 оны сүүлээр Ард Кредит нь Ард Аппаар дамжуулан Финтек зээлийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос авав.

Энэ хугацаанд Ард Кредит нь зээлийн багцаа мэдэгдэхүйц нэмэгдүүлж, 50 тэрбум төгрөгт хүргэлээ. Тодруулбал, он гарснаас хойш автомашины зээлийн багцыг PHYGITAL (Physical + Digital) хэлбэрээр өргөжүүлэхэд стратегийн ач холбогдол өгсний үр дүнд барьцаат зээлийн багц хурдацтай өсөж улмаар багцын хэмжээ даруй хоёр дахин нэмэгдэн 8 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Тус компани жилийн хугацаанд 45.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр шинээр татаж, 13 тэрбум төгрөгийн дахин санхүүжилт хийсэн нь энэхүү өсөлтөд голлон нөлөөлсөн байна. Ингэснээр 2.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, нэгж хувьцаа нь 119.9 төгрөгөөр хаагдаж зах зээлийн үнэлгээ нь 34 тэрбум төгрөгийг давлаа.

Ард Актив

Ард Актив нь нийт хөрөнгө, зээлийн багц, санхүүжилт зэрэг санхүүгийн гол үзүүлэлтийн хувьд тогтвортой, сайн өсөлт үзүүлж байна. Өнгөрсөн оны турш хадгаламж татах, сайн чанартай зээл олгох үндсэн үйл ажиллагаандаа голчлон төвлөрсний хүчинд эдгээр өсөлтийг үзүүлж чадсан байна.

Өнгөрсөн оны эцэст 31.5 тэрбум төгрөг байсан Ард Активын нийт хөрөнгө нилээдгүй нэмэгдэж, 44 тэрбум төгрөгт хүрснээр салбартаа II байр сууриа бататгаж чадсан.

Тайлант хугацаанд Ард Актив хадгаламж, зээлийн хоршоо 20.2 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шинээр татаж, 17.9 тэрбум төгрөгийг дахин санхүүжүүлж, нийт 38.1 тэрбум төгрөгийн хадгаламж татан төвлөрүүлээ. Цэвэр зээлийн багц 34.7 тэрбум төгрөг хүрч, санхүүжилт 32.9 тэрбум төгрөг болж өссөн. Улмаар 675.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа. Зээлийн багцын 0.4 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 0.4 хувийг чанаргүй зээлийн багц эзэлж байна.

Ард Лизинг

Ард Лизинг нь 2021 онд Өсдөг Машин хөтөлбөрөө туршилтын журмаар хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд IV улирлын байдлаар хөтөлбөрийн бүх тоон мэдээллийг нэгтгэн процессын зураглал гаргасан. Улмаар үүндээ суурилан уг хөтөлбөрөө дахин эхлүүлэхээр зорин ажиллаж байна. Энэ нь хөрөнгө оруулагчдыг татах, эргэн төлөлт санхүүжилтэд шаардлагатай мөнгөн урсгалыг нэмэгдүүлэхэд туслах, компанийн үйл ажиллагааны томоохон хэсэг болох юм.

Түүнчлэн, Ард Санхүү Нэгдлээс Ард Лизинг компанийг 18 тэрбум төгрөгийн хөрөнгөөр амжилттай хөрөнгөжүүлсэн.

Ард Кредит ББСБ - Жилийн тайлан үзэх



(Сая төгрөг)	Гол үзүүлэлт	2021	2022	2023	Жилийн өсөлт
Ард Кредит	Нийт хөрөнгө	73,387.80	58,038.70	72,005.50	24.06%
	Нийт эздийн өмч	22,605.30	18,049.40	20,904.90	15.82%
	Зээлийн багц (цэвэр)	34,177.80	40,038.10	47,941.90	19.74%
	Санхүүжилт	38,733.50	32,466.10	39,294.50	21.03%
	Чанаргүй зээл	7.00%	7.80%	7.10%	-8.97%
	Хугацаа хэтэрсэн зээл	9.20%	13.20%	11.80%	-10.61%
	Цэвэр ашиг	3,924.80	2,059.20	2,518.70	22.31%
	Зээлийн багцын задаргаа				
	Барьцаат зээл	10.80%	8.40%	16.20%	92.86%
	Цахим зээл	62.40%	52.60%	49%	-6.84%
Ард Актив	Бизнесийн зээл	26.80%	15.30%	9.90%	-35.29%
	СКОПА төслийн зээл	0%	23.70%	24.90%	5.06%
	Нийт хөрөнгө	30,228.70	31,487.70	43,971.80	39.65%
	Нийт эздийн өмч	7,836.60	8,107.70	8,804.20	8.59%
	Зээлийн багц (цэвэр)	20,626.40	25,441.90	34,744.60	36.56%
	Санхүүжилт	21,341.80	21,866.90	32,866.40	50.30%
	Чанаргүй зээл	0.12%	0.38%	0.41%	7.89%
	Хугацаа хэтэрсэн зээл	0.14%	0.63%	0.42%	-33.33%
	Цэвэр ашиг	406	711.7	675.8	-5.04%
	Зээлийн багцын задаргаа				
Ард Лизинг	Бизнесийн зээл	86.30%	84.30%	89.60%	6.29%
	Цалингийн зээл	8.10%	8.80%	3.90%	-55.68%
	Хэрэглээний зээл	2.30%	1.40%	0.90%	-35.71%
	Барьцаат зээл	3.20%	5.50%	5.60%	1.82%
	Нийт хөрөнгө	26,267.40	32,518.20	55,812.40	71.63%
	Нийт эздийн өмч	4,693.60	-9,384.60	141.2	-101.50%
	Зээлийн багц (цэвэр)	1,878.50	1,705.90	1,809.90	6.10%
	Санхүүжилт	18,399.70	35,291.40	51,534.00	46.02%
	Цэвэр ашиг	448.3	-3,398.80	-8,479.70	149.49%



Цахим зээл
24/7



Зээлийг
5 минутад



Хиймэл оюун ухаан
Кредит скоринг



Хариултаа
Хадгал

▲ 30%

Нийт хөрөнгө
₮116.0 тэрбум

▲ 26%

Зээлийн багц
₮82.7 тэрбум

▲ 33%

Санхүүжилт
₮72.2 тэрбум

▲ 15%

Цэвэр ашиг
₮3.2 тэрбум



Бизнес
₮59.6 тэрбум


Жижиглэн
₮14.9 тэрбум

Цахим
₮75.6 тэрбум



Эмэгтэй
55%

Эрэгтэй
45%



Даатгалын кластер

Ард Даатгал

Даатгалын кластерын хамгийн том компани болох Ард Даатгал нь өнгөрсөн онд санхүүгийн үзүүлэлтийн хувьд өндөр амжилт үзүүллээ. Компанийн нийт хураамжийн орлого 32.5 тэрбум төгрөгт хүрч, 8,819 нөхөн төлбөрийн хүсэлтэд нийт 14.1 тэрбум төгрөгийг төлжээ. Хөрөнгө оруулалтын багц, биет бус хөрөнгө, нөөцийн сангийн өсөлтөөс шалтгаалан нийт хөрөнгө 44.2 тэрбум төгрөгтэй хаагдав. Эдгээр эерэг үр дүнгийн хүчинд татварын дараах цэвэр ашиг 3.3 тэрбум төгрөгт хүрэв. Нээлттэй хувьцаат компанийн хувьд хувьцаа нь /MSE: AIC/ 874.53 төгрөгөөр хаагдаж, зах зээлийн үнэлгээ нь 22 тэрбум төгрөг боллоо.

Хөрөнгө оруулалтын багц 28 тэрбум төгрөгт хүрч, тогтмол өгөөжтэй хөрөнгө оруулалтыг багцдаа нэмснээр төрөлжилтийг нэмэгдүүлсэн байна.

Ард Даатгал нь Ард Аппаар дамжуулан зах зээлд хамгийн эрэлттэй бүтээгдэхүүний нэг болох Гуравдагч этгээдийн хариуцлагын даатгалыг харилцагчдад санал болгож эхлээд байна.

Мөн компани 140,000 гаруй тээврийн хэрэгслийг Жолоочийн Албан журмын даатгалд хамруулаад байгаа нь тус компанийг энэ төрлийн даатгалын зах зээлд тэргүүлэгч болгож байна.

(Сая төгрөг)	Гол үзүүлэлт	2021	2022	2023	Жилийн өсөлт
Ард Даатгал	Нийт хөрөнгө	34,826	35,645	44,156	23.88%
	Нийт эздийн өмч	18,396	16,679	18,218	9.23%
	Хөрөнгө оруулалтын багц	24,671	23,826	28,120	18.02%
	Нийт хураамжийн орлого	16,462	22,316	32,438	45.36%
	Нийт нөхөн олговор	4,967	7,859	14,095	79.35%
	Цэвэр ашиг	7,176	737	3,277	344.64%
Ардын Тэтгэврийн Данс	Нийт хөрөнгө	62,261	36,541	56,843	55.56%
	Нийт эздийн өмч	35,278	5,973	14,916	149.72%
	Хөрөнгө оруулалтын багц	58,468	34,741	49,689	43.03%
	Нийт тэтгэврийн хуримтлал	13,849	26,716	37,249	39.43%
	Тэтгэврийн хуримтлалын орлого	15,063	8,748	9,453	8.06%
	Цэвэр ашиг (алдагдал)	2,652	-12,088	-5,026	-58.42%
	Нийт дэлгэрэнгүй орлого	21,742	-29,306	-6,108	-79.16%

(Сая төгрөг)	Хөрөнгө оруулалтын багц	2021	2022	2023	Хувийн жин	Жилийн өсөлт
Ард Даатгал	Тогтмол өгөөжтэй	11,636	13,548	19,137	68.05%	41%
	Нээлттэй компанийн хөрөнгө оруулалт	9,523	6,662	4,838	17.20%	-27%
	Альтернатив хөрөнгө оруулалт	2,012	3,616	2,625	9.33%	-27%
	Бусад хөрөнгө оруулалт	1,500	0	1,520	5.41%	
	Нийт хөрөнгө оруулалтын багц	24,671	23,826	28,120	100%	18%
Ардын Тэтгэврийн Данс	Тогтмол өгөөжтэй	2,400	1,000	2,041	4.11%	104%
	Нээлттэй компанийн хөрөнгө оруулалт	37,686	20,994	36,092	72.64%	72%
	Альтернатив хөрөнгө оруулалт	14,051	7,255	9,581	19.28%	32%
	Үл хөдлөх	0	1,523	0	0.00%	-100%
	Хаалттай компанийн хөрөнгө оруулалт	4,032	3,976	1,975	3.97%	-50%
	Нийт хөрөнгө оруулалтын багц	58,169	34,748	49,689	100.00%	43%

Ардын Тэтгэврийн Данс

2023 оны 12 сарын 31-ний байдлаар Ардын Тэтгэврийн Данс компанийн хөрөнгө оруулалтын багц 49.7 тэрбум төгрөгт хүрч, хүүний өглөгийг оролцуулан нийт 37.2 тэрбум төгрөгийн тэтгэврийн хуримтлалыг бүрдүүлээд байна. Тайлант хугаанд 9.5 тэрбум төгрөгийн тэтгэврийн хуримтлал татсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьуулахад 8.7 хувиар өссөн үзүүлэлт юм. 1,212 харилцагч 1.4 тэрбум төгрөгийн тэтгэврийн хуримтлалаа цуцалж, 27 харилцагчид 422 сая төгрөгийн тэтгэврийг олгосон байна. Түүнчлэн, компанийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор бид байгууллагын борлуулалт руу хүчин чармайлтаа эрчимжүүлсэн жил байлаа. Үүний үр дүнд нийт 141,128 хувь хүн, 92 байгууллагын харилцагчидтай болоод байна.

Одоогийн байдлаар нийт хөрөнгө оруулалтын багцын 72 хувь нь нээлттэй компаниудаас бүрдэж байна. Үүнээс 45 хувь нь буюу 16.3 тэрбум төгрөг нь санхүүгийн салбарт чиглэсэн бөгөөд тээврийн салбарт 34 хувь буюу 12.2 тэрбум төгрөг, худалдааны салбарт 21 хувь буюу 7.6 тэрбум төгрөг, 0.14 хувь буюу 49.8 сая төгрөгийг бусад салбарт оруулсан байна.

Ард Даатгал ХК - Жилийн тайлан үзэх



Цахим даатгал
24/7



Даатгалаа
5 минутад



Хамгийн хялбар
Нөхөн төлбөр



Автомат
Хуримтлал

▲ 40%

Нийт хөрөнгө
₮101.0 тэрбум

▲ 46%

Эздийн өмч
₮33.1 тэрбум

▲ 35%

Нийт орлого
₮41.9 тэрбум

▲ 33%

Хөрөнгө оруулалтын багц
₮77.8 тэрбум



Эмэгтэй
55%
Эрэгтэй
45%



Эмэгтэй
58%
Эрэгтэй
42%



Хөрөнгө оруулалтын банкны кластер



Ард Секюритиз, Ард Менежмент, Ард Пропертиз компаниудаас бүрдсэн Ард Санхүүгийн Нэгдлийн Хөрөнгө Оруулалтын Банкны кластер нь Монголын хөрөнгийн зах зээлд олон талаар оролцож, 2023 оныг амжилттай тууллаа. Брокерын үйлчилгээгээр манлайлагч Ард Секюритиз нь Монголын Хөрөнгийн Бирж дээр 48.6 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжааг зуучилж, андеррайтер, санхүүгийн зөвлөх үйлчилгээний чиглэлээр амжилттай өргөжин 46.3 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн. МОСТ Финтек компанийн IPO-ний анхдагч зах зээлд андеррайтераар оролцож 5.7 тэрбумыг хөрөнгө оруулагчдаас татаж чадсан. Шинээр нэвтрүүлсэн Ухаалаг Хөрөнгө Оруулагч - үнэт цаасны хуримтлалын бүтээгдэхүүнд 2,000 гаруй хөрөнгө оруулагчид хамрагдаж, нийт 414 сая төгрөгийн багцыг бүрдүүлээд байна. Ард Менежмент нь 8.4 сая төгрөгийн цэвэр хөрөнгийн үнэлгээ бүхий хоёр хамтын хөрөнгө оруулалтын санг удирдаж байна. Ард Пропертиз нь үл хөдлөх хөрөнгийн зах зээлд шинэлэг бүтээгдэхүүн нэвтрүүлж, Блю Скай Тауэрын 9 давхрыг токентжуулж, хүн бүрт хаанаас ч, бага дүнгээр хотын А бүсэд байрлалтай оффисын талбайг эзэмших боломжийг олгоод байгаа бөгөөд тухайн талбайгаа урт хугацаагаар түрээслүүлэх гэрээ байгуулснаар токен эзэмшигчдэдээ сар бүр түрээсийн орлого хуваарилж байна.

Ард Секюритиз

Ард Секюритиз нь 2023 оны турш брокерын үйлчилгээний чиглэлээр өндөр амжилт үзүүлж, Монголын Хөрөнгийн Биржээр нийт 48.6 тэрбум төгрөгийн арилжааг зуучилжээ. Мөн тус компани андеррайтинг, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр туршлагаа зузаатгаж, нийт 46.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг босгоход нь хамтрагч талууддаа тусаллаа.

2023 оны онцлох төслүүдийн нэг нь МОСТ Финтек компанийн IPO -ний анхдагч зах зээлийн арилжаа байсан бөгөөд тус компанийн нэмэлт 27 хувийг санал болгож, ондоо багтан 1,500 гаруй хувьцаа эзэмшигчдээс 5.7 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлээ.

Ард Секюритиз нь жижиг хөрөнгө оруулагчдад урт хугацаанд өгөөжөө өгөх хуримтлалын дадал зуршлыг бий болгох зорилготой Ухаалаг Хөрөнгө Оруулагч - үнэт цаасны хуримтлалын бүтээгдэхүүнээ оны турш хөгжүүлж, одоогоор 2,000 гаруй хөрөнгө оруулагчид 414 сая төгрөгийн үнэлгээ бүхий үнэт цаасны хуримтлал нээгээд байна.

Түүнчлэн, Ард Секюритиз нь МХБ-ийн түүхий эдийн арилжаанд брокероор оролцох стратегийн шийдвэр гаргаж, тусгай зөвшөөрлийн бүх шаардлагыг, тэр дундаа өөрийн хөрөнгийн хүрэлцээний 3.4 тэрбум төгрөгөөс доошгүй байх ёстой гэсэн шаардлагыг хангаж чадсан ба 2023 онд зөвшөөрөл авах хүсэлтээ СЗХ-нд илгээж, зөвшөөрөл авсан байна.

Ард Менежмент

2023 онд Ард Менежмент нь нийт 8.4 тэрбум төгрөгийн цэвэр хөрөнгийн үнэлгээтэй хоёр хамтын санг удирдан ажиллаа. 2022 оноос эхэлсэн Монголын хөрөнгийн зах зээлийн уналт үргэлжилж байгаа ч бид дотоодын зах зээлийн урт хугацааны потенциалд итгэлтэй байгаа тул хоёр сангийн багцын дийлэнх хувийг дотоодын хувьцаа болон бондоос бүрдүүлсэн.

Ард Менежмент нь Монголын анхны нээлттэй хамтын хөрөнгө оруулалтын сан болох Хөрөнгө Оруулагч Үндэстэн Санг 2022 оны 10 сард эхлүүлсэн. Тус сан нь GARP хөрөнгө оруулалтын стратегийг баримталж, нийт хөрөнгийнхөө 6 хувийг санхүүгийн чиглэлийн компаниуд дийлэнхийг нь бүрдүүлэх 16 компанийн хувьцаанд байршуулаад байна. Хөрөнгө Оруулагч Үндэстэн Сан нь 1,078 нэгж эрх эзэмшигчтэй.

Хаалттай хөрөнгө оруулалтын сан болох Үндэсний Хувьчлалын Сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээ (ЦХҮ) жилийн хугацаанд 11 хувиар унасан ч байгуулагдсан цагаасаа хойш 25 хувийн өсөлтөө хадгалж чадсан. Сан нь дотоодын 25, гадаадын 5 хувьцаанаас бүрдсэн 30 ширхэг хувьцааны багцыг эзэмшдэг бөгөөд сангийн Монголын Хөрөнгийн Бирж дэх арилжааны хэмжээ 386 сая төгрөг, нэгж эрх эзэмшигчдийн тоо 6,328 байна. 2023 оны IV улирлын байдлаар сангийн ЦХҮ 126 төгрөгт хадгалагдан үлдсэн байна.

Өдөр тутмын үйл ажиллагааны хувьд бид хөрөнгө оруулагчдаа цаг үеийн мэдээллээр хангах зорилгоор вэбсайтаа шинэчлэн сайжруулах ажлыг эхлүүлсэн. Цаашилбал, бид Компанийн засаглалын кодекс болон бусад зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөхөөр тууштай ажиллаж байна. Мөн УБ Капитал хувийн сан байгуулах ажлыг эхлүүлээд байна.

Ард Пропертиз

Ард Пропертиз компани Блю Скай цамхагийн 9, 11 давхарт нийт 2,660.45 м.кв талбайг шинэчлэн засварлаж, урт хугацаагаар түрээслүүлэх гэрээг гуравдагч талуудтай байгуулсан.

Түүнчлэн, Хөх Тэнгэр төслийн хүрээнд Ард Пропертиз компани Айдакс биржтэй хамтран 6 сараас хойш токен эзэмшигчиддээ сар бүр түрээсийн орлогыг амжилттай хуваарилж байна. Идэвхтэй маркетингийн кампанит ажил явуулж эхэлснээр BS9 токены өдөр тутмын арилжааны эргэлт тогтмол өсч, 1,000 төгрөгөөс эхэлж байсан ханш нь 1090 төгрөгт хүрээд байна



Арилжаа
24/7




Автомат
Хуримтлал



Багц бүрдүүлэх
Боломж



Ухаалаг хөрөнгийн
Удирдлага



(Сая төгрөг)	Гол үзүүлэлт	2021	2022	2023	Жилийн өсөлт
Ард Секюритиз	Нийт хөрөнгө	20,340	8,997	8,889	-1.20%
	Эздийн өмч	15,459	6,104	6,498	6.45%
	Нийт орлого	3,216	2,695	3,472	28.83%
	Цэвэр ашиг	953	-647	191	129.52%
	Арилжаа	233,748	65,889	48,629	-26.20%
Ард Менежмент	Санхүүжилт	44,730	46,429	46,327	-0.22%
	Нийт хөрөнгө	7,889	2,513	3,857	53.48%
	Эздийн өмч	6,999	2,030	2,812	38.52%
	Нийт орлого	736	533	218	59.10%
	Цэвэр ашиг	118	-175	16	109.14%
Ард Пропертиз	Удирдлагад буй хөрөнгө	9,603	9,550	8,337	-12.70%
	Нийт хөрөнгө	29,898	10,196	27,973	144.93%
	Эздийн өмч	21,083	4,788	4,316	-9.86%
	Нийт орлого	2,458	518	1,516	192.66%
	Цэвэр ашиг	-146	-719	-834	-15.99%

A hand in a dark blue suit sleeve holds a red flag with a white logo. The background is a vast landscape with a bright blue lake, rolling green hills, and distant mountains under a blue sky with white clouds.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГ

#БидИлүүБайжЧадна



Veloo Foundation “Нарны хүүхдүүд” цэцэрлэг



29 дүгээр дунд сургууль



116 дугаар дунд сургууль



Гэр бүл Хүүхэд залуучуудын хөгжлийн төв

Ард Санхүүгийн Нэгдэл, Ард Академи, АрдКидс хамтран нийгмийнхээ сайн сайхны төлөө, тэр дундаа Монголын ирээдүй болсон хүүхэд рүү чиглэсэн БидИлүүБайжЧадна аянг санаачлан эхлүүлсэн билээ.

Уг аяны зорилго нь томчууд бид ирээдүй хойч үедээ илүү гэгээлэг, илүү сайн сайхан нийгмийг бүтээхэд өнөөдрөөс эхлэн дор бүртээ хичээж, бидний үргэлжлэл болсон үр хүүхдэдээ эерэг нөлөөлөл үзүүлж, энгийн алхмаас эхлэхэд оршино.

Аяны хүрээнд хүүхдийн баярыг тохиолдуулан: Нийслэлийн Ерөнхий Боловсролын 29 дүгээр дунд сургуулийн нийт сурагчдад Ирээдүйн Эзэн – Хүүхдийн хадгаламж, Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцаа (AARD) эзэмшүүлэв.

Veloo Foundation-ы төсөл болох “Нарны хүүхдүүд” цэцэрлэгийн 10 жилийн ойн баярт зочилж, цэцэрлэгийн нийт сурагчдад AARD эзэмшүүлэв.

Нийслэлийн Ерөнхий Боловсролын 116 дугаар дунд сургуулийн нийт сурагчдад Ирээдүйн Эзэн – Хүүхдийн хадгаламж, AARD эзэмшүүлэв.

Сэлэнгэ аймгийн хүүхэд багачуудад Монгол Улсын 0-18 насны хүүхэд бүрт олгогдох AARD хувьцаа эзэмшүүлэв.

Дархан Хотын Гэр бүл Хүүхэд залуучуудын хөгжлийн төв, Дархан хотын БТСпортын газартай хамтран зохион байгуулсан Дархан хот дахь “Эх, үрсийн баярын арга хэмжээ”-г дэмжиж, 3x3 уралдааны ивээн тэтгэгчээр оролцов.

Боловсрол



Аппрентис Монгол шоу нэвтрүүлэг - II



TomYo Edtech



Үндэсний мэтгэлцээний ЛИГ



Цалинтай Оюутан Хөтөлбөр

Санхүү, бизнесийн салбарт шинэ салхи оруулж, үзэгч түмний сайшаал, магтаал хүртээд байгаа Аппрентис Монгол шоуны II улирал цацагдав.

Ард Санхүүгийн Нэгдэл, TomYo Edtech хамтран иргэдийн боловсролд хөрөнгө оруулалт хийж, санхүүгийн боловсролыг хүртээмжтэй түгээхэд чиглэн ажиллав. Ингэхдээ Ард Апп хэрэглэгчид TomYo Edtech компанийн TomYo Skills, Tomyo Lingo платформуудад аппаараа төлбөр тооцоо хийх боломжийг нээв.

Шинэ үеийн дуу хоолой, үзэл бодлыг түгээж, бүтээлч байдлаар нийгэмд хэлэлцүүлэг өрнүүлэх талбар болох Үндэсний Мэтгэлцээний Лиг телевизийн шоу нэвтрүүлгийг ивээн тэтгэж, хамтран ажилласнаар залуусын ирээдүй, хөгжил төлөвшлийг дэмжив.

Оюутан залууст зориулсан Цалинтай Оюутан хөтөлбөрийг зарласан ба уг хөтөлбөрт хамрагдсанаар мэргэжлийн ур чадвараа сайжруулах боломжтойгоос гадна хичээл зүтгэл, чадвараараа манлайлсан нэг оюутанд бүтэн жилийн сургалтын төлбөрөөс чөлөөлөгдөх боломжийн эзэн болоод зогсохгүй ажлын байраар хангагдав.

Байгаль орчин



Offsetted платформ



Шамбала хамтын ажиллагаа



Тэрбум Мод

Ард Санхүүгийн Нэгдэл нь Сингапурт төвтэй тусгай зориулалтын компаниараа дамжуулан нүүрстөрөгчийн хийг бууруулах дэвшилтэт технологи бүхий Offsetted платформд хөрөнгө оруулав.

Шамбала Инженеринг Кампус ХХК хамтын ажиллагаа эхлүүлэв. Уг хамтын ажиллагааны хүрээнд тогтвортой ногоон байгууламжийг бий болгох, цөлжилтийг урлаг технологиор сааруулах чиглэлд хамтран ажиллана. Ингэхдээ Ард Апп хэрэглэгчид "ШАМБАЛА ИНЖЕНЕРИНГ КАМПУС ХХК"-ийн ART'N TECH төслөөс мод болон өөрийн модны дугаарлалттай мерчиндайзыг Ард Апп ашиглан худалдан авах боломжтой болсон юм.

Ард Санхүүгийн Нэгдлийн хамт олон "Тэрбум мод – Үндэсний хөдөлгөөн"-ийг дэмжиж, Инчьеон Мөрөөдлийн төгөлд 1,000 ширхэг мод тарих үйлсэд хамаарал бүхий 5 компанийн хамт идэвхтэй оролцож, 200 ширхэг мод тарилаа.

#БидИлүү
#БайжЧадна



Ардын компаниуд харилцагч нараа Ард Аппаа ашиглан үйлчлүүлэхийг уриалдаг ба үүний үр дүнд 2023 онд нийт **28,100,000** ширхэг цаасыг хэмнэснээр **3,249** ширхэг модыг хамгаалж чаджээ.

1 минутад
Хадгаламж хуримтлал нээх


ARDX
Гүйлгээ бүрт урамшуулал

10+
Санхүүгийн үйлчилгээ

100%
Цахим шийдэл



ЭКОСИСТЕМ



Зээл

- Хуваан төлөх үйлчилгээ
- Хэрэглээний зээл
- Хадгаламж барьцаалсан зээл
- Итгэлцэл барьцаалсан зээл

Даатгал

- Эрүүл мэндийн даатгал
- Гадаад аялалын даатгал
- Автомашины даатгал
- Жолоочийн албан журмын даатгал

Хуримтлал

- Тэтгэврийн хуримтлал
- Хүүхдийн хадгаламж
- Хугацаат хадгаламж
- Сирсаке

Хөрөнгө оруулалт

- Хувьцаа
- Бонд
- Ухаалаг хөрөнгө оруулагч
- Хөрөнгө оруулалтын сан

Технологи

- Ардсойны урамшуулал
- Төлбөрийн Шийдэл
- Интернет Банк



төвлөрсөн бус системд суурилсан
УРАМШУУЛЛЫН ОНОО



Биржүүд



Бүртгэгдсэн Платформууд



DeFi



IT



Мерчант



Санхүү



Платформ



Медиа



Зээл

- Бизнесийн зээл



Даатгал


- Ачаа тээвэр, ложистикийн даатгал
- Банк, Санхүүгийн даатгал
- Барилга угсралтын даатгал
- Хөрөнгийн даатгал
- Уул уурхайн салбарын даатгал
- Үйлдвэр, Худалдаа үйлчилгээний даатгал
- Үл хөдлөх хөрөнгийн даатгал
- Эрүүл мэндийн даатгал

Хуримтлал

- Байгууллагын тэтгэврийн хуримтлал

Хөрөнгө оруулалт


- Андеррайтер
- Өмчийн санхүүжилт
- Өрийн санхүүжилт
- Нагтгэн, нийлүүлэх M&A болон өөрчлөн байгуулах
- Зөвлөх үйлчилгээ



1,104,180

АРД АПП ХЭРЭГЛЭГЧ

Ард Апп



Ажаил аргачлалд суурилсан програм хангамж, хөгжүүлэлтийн стандартыг ашиглан Аппыг сайжруулах зорилгоор ГрэйпСити Монгол, МОСТ Финтек компаниудтай хамтарсан ажлын хэсэг тогтмол хоёр долоо хоногт нэг удаа аппликэйшны шинэчлэлтийг гарган ажиллаж байна.

12 сард санаачлан эхлүүлсэн Түмэн Ард хөтөлбөр нь Ард Аппын хэрэглээг нэмэгдүүлэх, ашиг тусыг нь олон нийтэд таниулах зорилготой бөгөөд энэхүү хөтөлбөр нь Ард Аппаар дамжуулан хэрэглэгч хадгаламж, хөрөнгө оруулалтаа удирдах дадал зуршлыг хөгжүүлэхэд чиглэсэн. Ард Аппаа тогтмол ашигласнаар сар бүр 1,000 Ардын Эрх цуглуулах боломжийг олгож байгаа юм.

Үзүүлэлт	2022	2023	Жилийн өсөлт
Нийт хэрэглэгч	1,055,828	1,104,180	4.50%
Шинэ хэрэглэгч	13,295	28,065	111.09%
Ард Кидс хэрэглэгч	36,921	52,515	42.20%
Нийт гүйлгээний тоо	997,593	3,635,595	364.43%
Хадгаламж (тэрбум төгрөг)	11.4	31.5	176.32%
Олгосон онлайн зээл (тэрбум төгрөг)	66.7	75.3	12.89%
Хувьцааны арилжаа (тэрбум төгрөг)	16	16.2	1.25%
Нийт шилжүүлэг (тэрбум төгрөг)	369.7	401.7	8.50%

Ард Апп

ТӨЛБӨРИЙН ШИЙДЭЛ

- QR төлөлт
- ПОС шийдэл
- Мессенжер шилжүүлэг
- Одоо аваад дараа төл

ТЕХНОЛОГИ

- Блокчэйн интеграц
- ХУР системийн интеграц
- Тоглоомжуулах

+1,600,000

Хэрэглэгч/харилцах данс

+400

Орон даяарх салбарууд

ЛАЙФСТАЙЛ

- Цахим худалдаа, тасалбар
- Гар утас, хэрэглээний төлбөр
- Санхүүгийн боловсрол
- Лотто

УРАМШУУЛАЛ

- Ардкойн
- Ардын Эрх

+48,000

Мерчант




- Зээл
- Лизинг
- Кредит карт
- Нийлүүлэлтийн санхүүжилт



- Хадгаламж
- Тэтгэврийн хуримтлал



- Эрүүл мэндийн даатгал
- Ердийн даатгал




- Санхүүгийн зөвлөх
- Үнэт цаасны арилжаа
- Брокер
- Андеррайтер



Ардын үнэнч харилцагч **танд...**

Хүчтэй. Хамтдаа.

АРДЫН БҮХ МЕРЧАНТ **АРДКОЙНООР** УРАМШУУЛДАГ БОЛЛОО



Хөрөнгө оруулалтын багц

Стратегийн түвшинд бүтцийн өөрчлөлт хийснээр Холдинг компанийн хөрөнгө оруулалтын багцад бүтцийн өөрчлөлт хийж, санхүүгийн бус чиглэлийн компаниудыг тусад нь гаргаж, Хөвсгөл ХК руу шилжүүлэв.



Ард Санхүүгийн Нэгдлийн ЭЗЭМШИЛ

Холбоотой этгээдийн ЭЗЭМШИЛ

МХБ дээр нээлттэй компани

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



Хувьцаа Эзэмшигчдийн Бүтэц



#	Хөрөнгө оруулалтын багц	2022	%	2023	%	Өөрчлөлт	Өөрчлөлтийн хувь
1	Эйч Ви Эл Эл ХХК	3,353,247	11.72%	2,775,406	9.70%	(577,841)	(2.02%)
2	Ардын Тэтгэврийн Данс ХХК	2,237,311	7.82%	2,517,778	8.80%	280,467	0.98%
3	Бруно Рашле	2,106,396	7.36%	2,109,997	7.37%	3,601	0.01%
4	А.Сүхдорж	1,941,591	6.79%	1,944,990	6.80%	3,399	0.01%
5	Ч.Ганхуяг	1,439,148	5.03%	1,590,466	5.56%	151,318	0.53%
6	Ард Венчурс ХХК	1,530,712	5.35%	1,429,244	4.99%	(101,468)	(0.36%)
7	Г.Уянга	1,388,900	4.85%	1,389,754	4.86%	854	0.01%
8	Голомт Кастодиан Банк	847,917	2.96%	900,000	3.15%	52,083	0.19%
	ARDT	847,917	2.96%	900,000	3.15%	52,083	0.19%
9	Ард Лизинг ХХК	761,207	2.66%	680,976	2.38%	(80,231)	(0.28%)
10	Ард Кредит ББСБ ХК	249,019	0.87%	525,489	1.84%	276,470	0.97%
11	С.Гэрэлтуяа	455,935	1.59%	455,935	1.59%	0	(0.00%)
12	Ронк Лимитед	443,816	1.55%	443,816	1.55%	0	(0.00%)
13	Ард Секюритиз УЦК	443,816	1.55%	400,988	1.40%	(42,828)	(0.15%)
14	С.Оргил	405,387	1.42%	390,937	1.37%	(14,450)	(0.05%)
15	Г.Бат-Эрдэнэ	390,937	1.37%	351,268	1.23%	(39,669)	(0.14%)
16	Н.Мөнхнасан	351,268	1.23%	344,311	1.20%	(6,957)	(0.03%)
17	Масик Энтерпрайзес	344,311	1.20%	321,078	1.12%	(23,233)	(0.08%)
18	Х.Батхишиг	321,078	1.12%	319,346	1.12%	(1,732)	(0.00%)
19	Ард Даатгал ХК	405,387	1.42%	253,265	0.89%	(152,122)	(0.53%)
20	Д.Отгонбаяр	233,303	0.82%	233,303	0.82%	0	0.00%
Топ 20		19,650,686	68.67%	19,378,347	67.74%	(272,339)	(0.94%)
Бусад		8,963,577	31.33%	9,235,916	32.28%	272,339	0.95%
Эргэлтэд буй хувьцаа		28,614,263	100%	28,614,263	100%	0	0.00%
Халаасны хувьцаа							
Нийт гаргасан хувьцаа		28,614,263					0.00%
Хувьцаа эзэмшигчид		18,822		19,069		247	
ARDT эзэмшигчид		3,064		3,061		(3)	
ARDT эзэмшигчид (хүүхдүүд)		0		55,166		55,166	



2023 онд Ард Санхүүгийн Нэгдлийн 10 жилийн ой тохиосон бөгөөд бид Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоо Эрхэм Зорилгынхоо хүрээнд энэхүү 10 жилийн хугацаанд нийт 50 гаруй компанийг нэгтгэн, нийлүүлэх, хөрөнгө оруулалт хийх замаар удирдаж ирсэн. Өнөөдрийн байдлаар бид 44 компанийг (үүнээс 8 нь нээлттэй) нэгтгэсэн Монголдоо тэргүүлэх финтек нэгдэл компани болсон байна. Өнгөрсөн 2023 онд бид бизнес төлөвлөгөөнийхөө дагуу санхүүгийн үндсэн 3 кластер болон бусад бизнесийг тусгаарлах бүтцийн өөрчлөлийг амжилттай хийж ажиллаа. Тус ажлын хүрээнд хийгдсэн эхний томоохон хэлцэл нь Хөвсгөл ХК-д хөрөнгүүдээ шилжүүлэх ажил байв. Хөвсгөл ХК-д Крипто Үндэстэн, ГрэйпСити Монгол, Гэр интерьер дизайн компаниудыг шилжүүлсэн бөгөөд УБУЦБ-ийн толгой компани болох Даац Инвестмент ХХК-ийг шилжүүлэх ажил хүлээгдэж байна. Бид цаашид Хөвсгөл ХК-ийн бүтцийн өөрчлөлтийг үргэлжлүүлэн хийж санхүүгийн бус нэгдэл компани болгохоор зорьж байна. Хоёр дахь томоохон хэлцэл нь Өндөрхаан ХК-ийн хэлцэл бөгөөд Ардын Тэтгэврийн Дансыг, Монгол Шуудан болон Тэнгэрлиг Медиа Нэгдлийн тодорхой хувийг тус тус шилжүүлсэн. Цаашид Өндөрхаан ХК-д Монголдоо анхдагч нээлттэй даатгалын нэгдэл компани болон хөгжих болно. Манай Нэгдлийн гурван үндсэн кластер болох Даатгал, Банк, Хөрөнгө оруулалтын Банкны кластер бүгд өөрсдийн бизнес төлөвлөгөөг биелүүлж, үндсэн бизнесийн хувьд өргөжин тэлсэн амжилттай ажиллаа.


Даатгалын Кластер: Ард Даатгал ХК нь 2023 онд 32 тэрбум төгрөгийн борлуулалт хийж компанийн түүхэн дэх дээд амжилтаа тогтоон даатгуулагчдын хамрагдалтаараа Монголдоо тэргүүлэгч компани боллоо. Даатгалын үйлчилгээ болон нөхөн төлбөрийг тус тус цахимжуулж Ард Апп-д байршуулан цахим даатгалын компани болох зорилт руугаа ойртсоор байна. 146 мянга гаруй тэтгэврийн хуримтлалын данстай Ардын Тэтгэврийн Данс нь сарын борлуулалтаа тогтмол өсгөхөөс гадна стратегийн шийдвэр болох ӨндөрХаанд нэгдэх бүтцийн өөрчлөлтийг амжилттай хийлээ.

Банкны Кластер: Хамгийн олон хувьцаа эзэмшигчтэй банк бус санхүүгийн байгууллага болох Ард Кредитын зээлийн багц нь 50 тэрбум төгрөгт хүрч, үйл ажиллагааны хүрээнд дараагийн шатанд гаран олон нийтэд нэмэлт хувьцаа санал болгож, 8.9 тэрбум төгрөгийн хөрөнгийг амжилттай татан төвлөрүүлээ. Ингэснээр Ард Кредит ойрын ирээдүйд зээлийн багцаа үлэмж нэмэгдүүлэх боломжтой болсон болно. 4,500 гаруй гишүүдтэй Ард Актив нь сэлтийн эрчээ хадгалсаар зээлийн багц нь 30 тэрбум төгрөгийн босгыг давж, салбартаа активын хэмжээгээрээ хоёрдугаарт жагсаж эхлэв.

Хөрөнгө Оруулалтын Банкны Кластер: Ард Секюритиз нь 2023 онд 46 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хөрөнгийн зах зээлээс босгосон бол Ард Менежмент болон түүний удирдаж буй хамтын сангуудын үйл ажиллагаа улам эрчимжиж эдийн засгийн хүнд нөхцөлд хөрөнгө оруулалтын багцын бодит үнэ цэнийг унагаалгүй ажиллаж чадсан нь томоохон амжилт байлаа.

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо

+110,000





Чулууны Ганхуяг

ТУЗ-ийн Дарга,
Ард Санхүүгийн Нэгдэл

Унгар Улсын Будапешт хотын Корвинус Эдийн Засгийн Их Сургуулийг дүүргэсэн тэрээр 1991 онд Монголын Хөрөнгийн Биржээс хөдөлмөрийн гараагаа эхэлж, Монголбанкинд хянан шалгагчаар оржээ. 1998 онд НҮБын бичил санхүүгийн Микростарт төсөл дээр Санхүүгийн менежерээр шалгаран ажиллаж байгаад 1999 онд Монголын анхны банк бус санхүүгийн байгууллага болох Хөгжлийн Алтан Сан (ХАС)-г байгуулан, Гүйцэтгэх захирлаар томилогдсон юм.

ХАС нь бичил зээлийн үйл ажиллагааг амжилттай явуулсаар 2001 онд Говийн Эхлэл ББСБ-тай нэгдэж, өнөөгийн ХасБанк байгуулагдсан түүхтэй. Ч.Ганхуяг нь ХасБанк байгуулагдсан цагаас хойш 2009 оныг хүртэл Гүйцэтгэх захирлаар ажилласан бөгөөд 2009-2010 онд ХасБанкны толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн Гүйцэтгэх захирал, 2010-2012 онд Монгол Улсын Сангийн Дэд сайдаар тус тус ажиллаж байв.

Тэрээр Унгар улсын өргөмжит консул, Монголын Эдийн Засгийн Форумын санаачлагч, Ерөнхий нарийн бичгийн дарга, Монголын Оюутны Холбооны Ерөнхийлөгч, Олон Улсын Бичил Санхүүгийн Төвийн ТУЗ-ийн гишүүн, Монголын Сагсан Бөмбөгийн Холбооны Ерөнхийлөгч гэх мэт албан тушаал хашиж байснаас гадна Монгол Улсад анхлан хадгаламж зээлийн хоршооны хөдөлгөөнийг 1990-ээд оны сүүлээр эхлүүлсэн.

2009 онд Дэлхийн Эдийн Засгийн Форумаас түүнийг Дэлхийн Залуу Манлайлагчаар өргөмжилсөн. Мөн Улаанбаатар Хотын Худалдааны Танхимын Ерөнхийлөгчийн сонгуульд ажлыг давхар хашдаг. Ч.Ганхуяг нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд тус компанийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



Бруно Рашле

Дэд Дарга,
Шродер Капитал Холдинг

Швейцарын Холбооны Технологийн Институтыг барилгын инженерийн чиглэлээр, Стэнфордын их сургуулийг аж үйлдвэрийн инженер мэргэжлээр магистр зэрэгтэй төгссөн бөгөөд 1990 онд Харвардын Их Сургуульд дэвшилтэт менежментийн хөтөлбөрийг дүүргэсэн Бруно Рашле 1997 онд Адвек Группыг үүсгэн байгуулж, Гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаад 2017 онд компаниа Шродер Группд худалдсан байна.

Шродер Адвек нь хувийн хөрөнгө оруулалтын менежментийн төрөлжсөн үйлчилгээ үзүүлдэг компани юм. Тус компани нь харилцагч санхүүгийн байгууллагуудаас хуримтлуулсан 10 гаруй тэрбум долларын санг удирдаж, дэлхийн хэмжээнд анхдагч болон хоёрдогч зах зээл дээр хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулж байна.

Адвекыг үүсгэн байгуулахаас өмнө Бруно Рашле нь Швейцарийн МоторКолумбусын сангийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт ЭмСи Партнерс сангийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байжээ. Тэрээр 5 тивд байрлах, төрөл бүрийн аж үйлдвэрүүдийн төслийг эхлүүлэх, нэмэлт хөрөнгө оруулах, үйл ажиллагааг нь өргөжүүлэх төсөл хөтөлбөрийг удирдсан туршлагатай.



Авирын Сүхдорж

Үүсгэн байгуулагч,
ГрэйпСити Монгол

Украин улсын Киев хотын Политехникийн их сургуулийг компьютерын инженер мэргэжлээр төгссөн А.Сүхдорж нь 1975 оноос Улсын Төлөвлөгөөний комиссоос ажлын гараагаа эхэлж төд удалгүй Монгол Улсын төв банкны Тооцоолон Бодох төвийн даргаар томилогдон ажилласан.

Социалист тогтолцооноос зах зээлийн эдийн засагт шилжсэний дараахан 1991 онд Монгол Улсын анхны мэдээллийн технологийн компани болох БСБ группыг үүсгэн байгуулсан байна. БСБ группын ТУЗ-ийн дарга, ерөнхий захирлаар ажиллаж байх хугацаандаа 2000 онд банк санхүү, төлбөрийн шийдлийн программ хангамжийн компани болох ГрэйпСити ГрэйпСити Монгол ХХК-ийг үүсгэн байгуулж, 2001 онд сансрын холбооны үйлчилгээ үзүүлэгч Инкомнет ХХК-ийг байгуулсан юм. ГрэйпСити Монгол нь эдүгээ Монгол Улсын банк санхүү, төлбөрийн шийдлийн программ хангамжийн тэргүүлэгч компани болжээ.

Тэрээр Монголын Мэдээлэл Харилцаа Холбооны хөгжлийн түүчээлэгч бөгөөд банк санхүү, төлбөрийн секторын хөдөлгөгч хүч болсоор ирсэн. Өнгөрсөн 40 жилийн хугацаанд олон тооны амжилттай төслүүд хэрэгжүүлсэн ба 2008 онд улсын хэмжээний анхны төлбөрийн үйлчилгээний оператор компанийг байгуулж (Мост Финтек ХХК), 2012 онд цахим төлбөр тооцооны МОСТ Мони мобайл хэтэвч үйлчилгээг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн юм.



Одончимэдийн Одбаяр

Гүйцэтгэх Захирал,
Мон-Интернэшнл

Зөвлөлт Холбоот Улсын Киев хотын Багшийн Их Сургуульд багш мэргэжлээр суралцсан. Монгол Улсын магистрант зэрэгтэй. АНУ-ын Флорида мужийн Техникийн Их Сургуулийн Эдийн засгийн сургуульд олон улсын эдийн засагч, 1997-2000 оны хооронд Отгонтэнгэр Их Сургуульд хуульч, эрх зүйч, 2017 онд АНУ-ын Бостон хотын Харвардын Их Сургуульд бизнес удирдлагын чиглэлээр тус тус суралцаж төгссөн.

О.Одбаяр нь Монгол Хятадын хамтарсан Төрийн Өмчит Улсын Үйлдвэрийн Газрын захирал, Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны Атташе, Гуравдугаар нарийн бичгийн дарга, 2010-2012 онд Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, Алтай Холдинг ХХК-ийн Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байв.

2016 оноос Төрийн өмчит Эрдэнэс Монгол компанийн Бизнес хөгжлийн асуудал эрхэлсэн дэд захирлын албыг хашиж, төрийн өмчит аж ахуйн нэгж, стратегийн холбогдол бүхий ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, байгалийн баялгийг олборлох, боловсруулах, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн төслүүдийг удирдан, түүний үр өгөөжийг баялгийн сангаар дамжуулан Монгол Улсын нийт ард иргэдэд хүртээх ажлыг хийж гүйцэтгэжээ.



Арно Вентура

Үүсгэн байгуулагч,
Баобаб Группт

Арно Вентура нь бичил, жижиг бизнесүүд рүү чиглэсэн, Африк тив, Хятад улсад тэргүүлэгч дижитал бичил санхүүгийн групп болох Баобаб Группын үүсгэн байгуулагч.

Баобабын эрхэм зорилго нь үйлчлүүлэгчдэдээ энгийн, амар хялбар санхүүгийн үйлчилгээ үзүүлэх замаар тэдний боломж бололцоог нээхэд туслах явдал юм. 2005 онд МикроКредит нэртэйгээр үүсгэн байгуулагдсан тус компани нь 2018 онд 1 тэрбум евротой тэнцэх санхүүжилтийг цахимаар болон мянга гаруй салбар, үйлчилгээний цэгүүдээрээ дамжуулан олгосон. Баобаб нь Африк, Хятадад үйл ажиллагаагаа явуулдаг 4,000 гаруй ажилтантай бөгөөд 1 сая орчим харилцагчидтай.

Баобабыг үүсгэн байгуулахаас өмнө Арно Вентура нь Планет Финанс гэх олон улсын хөгжлийн болон бичил санхүүгийн салбарт тэргүүлэх, олон улсын байгууллагыг үүсгэн байгуулахын сацуу Позитив Экономик Форум хэмээх нийгэмд чиглэсэн, Европын томоохон чуулга уулзалтыг санаачлан, хамтран зохион байгуулж байв.

Арно 2005 онд Францын, мөн 2013 онд Дэлхийн эдийн засгийн форумаас “Дэлхийн залуу удирдагч”-аар тус тус нэрлэгдсэн байна.

Планет Финансыг үүсгэн байгуулахаасаа өмнө тэрээр Франц, Аргентинд БНП Парибас банкинд ажиллаж байсан бөгөөд Франц, Тайландад тэргүүлэх интернетийн үйлчилгээг ханган нийлүүлэгч компанийг үүсгэн байгуулах ажилд гар бие оролцжээ.



Мөнх-Очирын Сэргэлэн

Захирал,
ТТДС

Япон улсын Исити коллежийг менежментийн чиглэлээр, Бизнес, олон улсын дээд сургуулийг нягтлан бодогчоор тус тус төгссөн. М.Сэргэлэн нь Техник Технологийн Дээд сургуулийн Ерөнхийлөгч, Монгол Коосэн Коллежийн захирлаар тус тус ажиллаж байна.

Тэрээр TCI компанийн захирал, MAC компанийн захирлаар тус тус ажиллаж байв. 2018 оны 5 сараас Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллаж эхэлсэн.



Михиал Зелдович

Хяналтын зөвлөлийн дарга,
Кокуун капитал

Харвардын Хуулийн сургууль болон Флетчерийн Хууль, Дипломатын сургууль төгссөн. Михаил Зелдович хөгжиж буй зах зээлд хөрөнгө оруулах, худалдааны хэлэлцээр хийх, зөвлөгөө өгөх ТУЗ-ийг удирдсан 20 гаруй жилийн туршлагатай, мэргэшсэн хөрөнгө оруулагч бөгөөд түүхий эдийн арилжаа эрхлэгч юм. Тэрээр 2.2 тэрбум долларын хөрөнгө оруулалтын сангийн менежерээр ажиллаж байсан ба Бостон Консалтинг Группын зөвлөх, АНУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газрын худалдааны хэлэлцэгчээр тус тус ажиллаж байв.

Одоогоор Михаил Зелдович нь Зүүн Өмнөд Азийн үр тарианы хөрөнгө оруулалтын сан Кокуун Капиталын ТУЗ-ийн даргаар ажиллаж байгаа ба ногоон технологи, хөдөө аж ахуйн технологи, цахим аюулгүй байдал, байгалийн баялгийн салбарт бие даан хөрөнгө оруулдаг.

Мөн дэлхийн зах зээл дээр түүхий эд арилжаалагч Трафигура компанийн бүс нутгийн тэргүүнээр 10 гаруй жил ажиллаж байна. Монгол Улсын эрчим хүчний хараат бус байдалд оруулсан хувь нэмрийг нь төрөөс өндрөөр үнэлж, түүнийг Алтан гадас одонгоор шагнажээ.



Чулууны Мөнхбат

Дэд ерөнхийлөгч,
Саусгоби Ресурс Лимитед

ОХУ-ын Ленинград хотын дээд сургуулийг хуульч мэргэжлээр төгссөн ба Монгол Улсын Удирдлагын академийн Төрийн удирдлагын магистр, Шинэ Зеланд Улсын Вайкато их сургуульд Төрийн бодлого, удирдлагын чиглэлийн магистрын зэрэг хамгаалсан. Ч.Мөнхбат нь 2015 оны 9 сарын 7-ны өдрөөс Саусгоби Сэндс ХХК-ийн Ерөнхийлөгч мөн Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна.

Ажлын гараагаа Саусгоби Ресурс компанид Зөвлөхөөр ажиллаж эхлүүлсэн бөгөөд улмаар Саусгоби сэндс ХХК-ийн Засгийн газрын харилцаа, Бодлогын хэрэгжилт хариуцсан захирлаар ажиллаж байв. Үүний өмнө тэрбээр Азийн Хөгжлийн Банкнд Төслийн захирлаар, Дэлхийн Банкнд Зохицуулагчаар тус тус ажиллажээ. Ч.Мөнхбат нь Шинэ Зеландын Монгол Улс дахь "Өргөмжит консул" юм.



Роланд Нэш

Үүсгэн байгуулагч түнш,
VPE Капитал

Роланд нь VPE Капитал компанийн үүсгэн байгуулагч бөгөөд VPE Капитал нь одоогоор Барселон, Абу Даби, Алматы зэрэг хотоос хөгжиж буй зах зээл рүү чиглэсэн вэнчур капиталын үйл ажиллагаа явуулж байна. Тэрээр банк, дэд бүтэц, үл хөдлөх, тоглоом, эдтек, эрүүл мэнд, бүтээлч үйлдвэрлэл, ногоон эрчим хүч зэрэг олон салбарт хөрөнгө оруулалт хийж, хөрөнгө оруулалтын сан удирдахад оролцож байв.

Роланд нь VPE компаниаас гадна Кен, Гүрж Улсад үл хөдлөх хөрөнгийн төслүүдэд оролцсон байна. Тэрээр рестораны менежментын компани болох Schmuckordie, Каталун дахь үл хөдлөх хөрөнгийн чиглэлээр мэргэшсэн Испанийн Molist 16S-ын хөрөнгө оруулагч юм. Түүнчлэн Роланд Украин, Киргизстан, Казакстан, Нигер, ОХУ, Арабын Нэгдсэн Эмират, Малта зэрэг улс орнуудад бизнес эхлүүлж, хөгжүүлэхэд Ренессанс Капитал компанийн удирдлагад 1996-аас 2010 он хүртэл ажиллаж байхдаа гар бие оролцсон туршлагатай.

#	Хувьцаа эзэмшигч	2022	%	2023	%	Өөрчлөлт, тоо
1	Ч.Ганхуяг	1,439,148	4.80%	1,590,466	5.56%	151,318
2	Бруно Рашле	2,106,396	7.40%	2,109,997	7.37%	3,601
3	А.Сүхдорж	1,941,591	4.30%	1,944,990	6.80%	3,399
4	М.Сэргэлэн	64,911	0.20%	48,347	0.17%	-16,564
5	Ч.Мөнхбат	39,430	0.10%	43,838	0.15%	4,408
6	Арно Вентура	17,637	0.00%	21,427	0.07%	3,790
7	О.Одбаяр	2,649	0.00%	8,007	0.03%	5,358
8	Михаил Зелдович	3,383	0.00%	6,902	0.02%	3,519
9	Роланд Нэш	0	0.00%	0	0.00%	0
	Нийт	5,615,145	19.62%	5,773,974	20.18%	158,829



Удирдлагын баг



Батбилэгийн Золбоо
Гүйцэтгэх Захирал
Ард Санхүүгийн Нэгдэл ХК



Өнөрбаянгийн Ашхүү
Ахлах Хуулийн Зөвлөх
Ард Санхүүгийн Нэгдэл ХК



Хүрэлбаатарын Билгүүн
Санхүү Эрхэлсэн Захирал
Ард Санхүүгийн Нэгдэл ХК



Ганхуягийн Сэлэнгэ
Ерөнхий Нягтлан Бодогч
Ард Санхүүгийн Нэгдэл ХК



Буяндэлгэрийн Уянга
Хүний Нөөц Хариуцсан Захирал
Ард Санхүүгийн Нэгдэл ХК



Мөнхбатын Мөнх-Эрдэнэ
Дотоод Аудитор
Ард Санхүүгийн Нэгдэл ХК



Жаргалсайханы Дашням
Дижитал Стратеги Эрхэлсэн Захирал
Ард Санхүүгийн Нэгдэл ХК



Эрдэнэбаатарын Төртогтох
Эрсдэл Эрхэлсэн Захирал
Ард Санхүүгийн Нэгдэл ХК

Охин компанийн удирдлагууд



Галбадрахын Цогбадрах
Гүйцэтгэх Захирал
Ард Даатгал



Ганхуягийн Билгүүн
Гүйцэтгэх Захирал
Ард Актив



Гэрэлтийн Тэлмэн
Гүйцэтгэх Захирал
Ард Кредит



Чулуунбаатарын Хандаа
Гүйцэтгэх Захирал
Ард Менежмент



Отгонбаярын Амарболд
Гүйцэтгэх Захирал
Ардын Тэтгэврийн Данс



Гүррагчаагийн Сүхбаатар
Гүйцэтгэх Захирал
Ард Лизинг



Гүнрэгийн Долгорсүрэн
Гүйцэтгэх Захирал
Ард Секюритиз



Цэнд-Аюушийн Солонго
Гүйцэтгэх Захирал
Ард Суппорт




Галнямын Уянга
Гүйцэтгэх Захирал
Ард Пропертиз

Хувьцааны арилжаа



MSE: AARD



Нээлт	₮3,301
52 долоо хоног	₮2,975 - ₮4,700
Хаалт (2023/12/28)	₮3,506
33Ү	₮100.3 тэрбум

(тэрбум төгрөг)	2021	2022	2023
Хувьцааны эргэц	33.0%	13.0%	9.2%
Арилжааны дүн	72.2	23.1	8.7
МХБ нийт хувьцааны хоёрдогч арилжааны дүн	230.2	167.6	174.1
AARD эзлэх хувь	31.4%	13.8%	5.0%


Хувьцааны арилжаа



Тикер	2023У4 (Улирлын)		52 долоо хоног	
	Дээд	Доод	Дээд	Доод
AARD	3,650.00	3,006.00	4,700.00	2,975.00
AIC	899.9	700	899.9	681.1
ADB	129	102.1	139	95
MNP	877	681	975	657.2
TNGR	10,000.00	6,600.00	15,000.00	6,600.00
CNF	80,000.00	42,400.00	90,000.00	42,400.00
XOC	109.9	92	116.9	92
% of MSE				

2023У4 (Улирлын)		52 долоо хоног		2023.12.31	
Арилжааны дүн	Эргэц %	Арилжааны дүн	Эргэц %	Хаалтын ханш	33Ү
2.66B	2.94%	8.66B	9.19%	3,506	100.32B
0.12B	0.60%	1.60B	7.60%	874.53	21.86B
0.71B	2.02%	1.95B	5.95%	119.9	33.57B
0.49B	0.58%	1.17B	1.43%	847.96	84.45B
0.12B	0.27%	0.63B	1.13%	10,000	60.00B
0.49B	8.24%	1.03B	15.47%	79,300	8.98B
0.08B	1.76%	0.38B	7.55%	106.42	5.32B
0.17%		1.06%			2.71%

(сая төгрөг)	Суурь	2022	%	2023	%	Жилийн өсөлт
Стратегийн хөрөнгө оруулалт		91,698		76,749		(16.3%)
Ард Кредит (MSE: ADB)	MV	14,630	41%	13,747	41%	(6.0%)
Ард Актив	BV	804	10%	877	10%	9.1%
Ард Лизинг	Cost	1	100%	18,197	100%	
Ард Даатгал (MSE: AIC)	MV	10,535	45%	9,950	45%	(5.6%)
Өндөрхаан (MSE: ONH)	MV			620	23%	
Ардын Тэтгэврийн Данс	BV	9,510	95%	0	0%	(100.0%)
Ард Секюритиз	BV	5,644	90%	5,849	90%	3.6%
Ард Менежмент	BV	1,870	100%	2,807	100%	50.1%
Ард Пропертиз	BV	4,788	100%	4,783	100%	(0.1%)
ТэнГэр Системс	BV	1,076	100%	0	100%	(100.0%)
Монгол Шуудан (MSE: MNP)	MV	16,008	20%	7,999	9%	(50.0%)
Хөвсгөл (MSE: HVL)	MV			6	93%	
Ард Венчурс	BV	0	0%	0	0%	
Ард Бит	BV	0	0%	0	0%	
Айдакс	DCF	0	0%	0	0%	
Даац Инвестмэнт (УБҮЦБ-ийн 54%)	Cost	4,096	51%	4,096	51%	0.0%
ТэнГэрЛиг Медиа Нэгдэл	MV	22,737	38%	6,605	11%	(70.9%)
ГрэйпСити Монгол	Cost					
МОСТ Финтек (UBX: MOST)	MV			1,213	4%	
Тактикийн хөрөнгө оруулалт		1,069		6,120		472.5%
Үндэсний Хувьчлалын Сан (MSE: XOC)	MV	26	0%	44	1%	69.2%
КриптоҮндэстэн (MSE: CNF)	MV	589	6%	7	0%	(98.8%)
Бусад санхүүгийн хэрэгслүүд		454		6,069		1,236.8%
Бусад		40,015		4,807		(88.0%)
Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгө		13,632		1,151		(91.6%)
Бэлэн мөнгө		4		329		
Бусад цэвэр хөрөнгө		26,379		3,327		(87.4%)
Нийт үнэлгээ	Э	132,781		87,676		(34.0%)



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ
ҮНДЭСТЭН

ARD САНХҮҮГИЙН
НЭГДЭЛ

ARD | ДААТГАЛ
SINCE 1994

ARD КРЕДИТ
ББСБ

ARD АКТИВ
ХЗХ

ARD СЕКЮРИТИЗ
ҮЦК

ARD ТЭТГЭВРИЙН
ДАНС

ARD ПРОПЕРТИЗ
КОМПАНИ

ARD ЛИЗИНГ
КОМПАНИ

ARD МЕНЕЖМЕНТ
КОМПАНИ

ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ
ҮНДЭСТЭН
БАЯЛГИЙН САН

UBX Ulaanbaatar
Securities Exchange

CRYPTO
NATION

ARD BIT

idax

M·O·S·T
FINTECH

Diverse Solutions

Lotto42

ТЭНГЭРЛИГ
МЕДИА ГРУПП

МОНГОЛТВ

TENGER HD

UNREAD™

ORI

ORISTUDIOS



Удирдлагын мэдэгдэл

Удирдлага нь тусдаа санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, Компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусвар болсон үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу зохистой толилуулах үүрэгтэй.

Тусдаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага дараах үүрэг хариуцлагыг биелүүлсэн. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгох, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн.
- Компанийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.
- Тусдаа санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагаанд үндэслэн бэлтгэсэн.
- Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, ирээдүйн үйл ажиллагаанд алдагдал хүлээж болзошгүй зүйлсийг байнга хянаж байх үүрэгтэй бөгөөд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага, болзошгүй зүйлсийн талаар тодруулсан.

"Ард санхүүгийн нэгдэл" ХК-ийн ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Золбоо болон Санхүү эрхэлсэн захирал Х.Билгүүн бид энэхүү тайлангийн 13-51 дүгээр хуудсанд үзүүлсэн компанийн санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх компанийн санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

Ч.Ганхуяг
ТУЗ-ийн дарга

Б.Золбоо
Гүйцэтгэх захирлын үүрэг
гүйцэтгэгч

Х.Билгүүн
Санхүү эрхэлсэн захирал

Огноо: 2024/04/19

Огноо: 2024/04/19

Огноо: 2024/04/19



Ард санхүүгийн нэгдэл ХК
Тусдаа санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2023 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

Тусдаа санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2023 оны 12 сарын 31- ний үлдэгдэл	2022 оны 12 сарын 31- ний үлдэгдэл
Хөрөнгө			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7	328,802	3,917
Дансны болон бусад авлага	8	53,549,894	21,637,849
Бусад санхүүгийн хөрөнгө	9	705,265	366,054
Бараа материал	10	104,242	97,615
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	11	10,939,632	4,643,904
Эргэлтийн хөрөнгийн дүн		65,627,835	26,749,339
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	12	428,829	418,606
Биет бус хөрөнгө	13	262,280	12,020,050
Ашиглах эрхтэй хөрөнгө	14.1	460,038	1,281,761
Урт хугацаат хөрөнгө оруулалт	15	82,162,831	96,138,283
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		83,313,978	109,858,700
Нийт хөрөнгө		148,941,813	136,608,039
Өр төлбөр ба эздийн өмч			
Өр төлбөр			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны болон бусад өглөг	16	21,834,791	3,598,232
Богино хугацаат зээл	17	6,852,426	2,578,483
Богино хугацаат хаалттай бондын өр төлбөр	18	370,000	2,603,000
Богино хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	14.2	608,298	865,676
Урьдчилж орсон орлого	19	19,407,578	9,965,930
Богино хугацаат өр төлбөрийн дүн		49,073,093	19,611,321

"Ард санхүүгийн нэгдэл" ХК
Тусдаа санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2023 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

Тусдаа санхүүгийн байдлын тайлан (үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	Тодруулга	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	14.2	-	608,298
Урт хугацаат зээл	17	12,193,298	6,589,586
Хойшлогдсон татварын өр	20	3,413,193	6,186,750
Урт хугацаат өр төлбөрийн дүн		15,606,491	13,384,634
Өр төлбөрийн нийт дүн		64,679,584	32,995,955
Эздийн өмч			
Өмч-хувьцаат	21.1	28,614,263	28,614,263
Нэмж төлөгдсөн капитал	21.3	2,927,696	2,927,696
Дахин үнэлгээний нөөц	21.5	28,362,014	52,792,679
Эздийн өмчийн бусад хэсэг		13,799	13,799
Хуримтлагдсан ашиг	21.4	24,344,457	19,263,647
Эздийн өмчийн дүн		84,262,229	103,612,084
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		148,941,813	136,608,039

Уг тусдаа санхүүгийн байдлын тайланг 2024 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр батлав:

Ч.Ганхуяг
ТУЗ-ийн дарга

Б.Золбоо
Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч

Х.Билгүүн
Санхүү эрхэлсэн захирал

Огноо: 2024/04/19

Огноо: 2024/04/19

Огноо: 2024/04/19

Хуудас 13-51-д харуулсан тодруулгууд нь энэхүү тусдаа санхүүгийн байдлын тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

"Ард санхүүгийн нэгдэл" ХК
Тусдаа санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2023 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

Тусдаа ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2023 он	2022 он
Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээний орлого	22.1	1,885,664	2,837,210
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз	22.2	5,969,146	3,657,162
Ногдол ашгийн орлого	22.3	45,722	1,012,491
Хөрөнгө оруулалтын багцын хүүгийн орлого	22.4	1,067,360	18,246
Нийт хөрөнгө оруулалтын орлого		8,967,892	7,525,109
Хөрөнгө оруулалтын бус бусад орлого	23	3,024,182	6,250,462
Борлуулалт, маркетингийн зардал	24	(1,193,239)	(2,227,526)
Ерөнхий ба удирдлагын зардал	25	(6,341,019)	(5,667,047)
Санхүүгийн зардал	26	(3,641,911)	(3,159,929)
Бусад зардал	27	(1,830,491)	(1,633,147)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		102,551	(30,959)
Виртуал хөрөнгийн үнэлгээний гарз		-	(17,653)
Виртуал хөрөнгийг данснаас хассаны олз	28	1,497,273	1,251,464
Татвар төлөхийн өмнөх ашиг		585,238	2,290,774
Орлогын татварын зардал	29	(469,566)	(180,049)
Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг		115,672	2,110,725
Зогсоосон үйл ажиллагааны ашиг	30	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг		115,672	2,110,725
Бусад дэлгэрэнгүй орлого			
Хөрөнгө оруулалт болон виртуал хөрөнгийн үнэлгээний (гарз)		(19,465,527)	(155,722,397)
Бусад дэлгэрэнгүй орлогын дүн		(19,465,527)	(155,722,397)
Нийт дэлгэрэнгүй алдагдал		(19,349,855)	(153,611,672)
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		(0.02)	0.07

Хуудас 13-51-д харуулсан тодруулгууд нь энэхүү тусдаа орлогын дэлгэрэнгүй тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

"Ард санхүүгийн нэгдэл" ХК
Тусдаа санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2023 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

Тусдаа өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	28,614,263	2,927,696	214,347,421	13,799	12,653,428	258,556,607
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	2,110,726	2,110,726
Хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	-	-	(155,722,397)	-	-	(155,722,397)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	(1,332,852)	(1,332,852)
Дахин үнэлгээний нөөцийн хэрэгжсэн дүн	-	-	(5,832,345)	-	5,832,345	-
2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	28,614,263	2,927,696	52,792,679	13,799	19,263,647	103,612,084
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	115,672	115,672
Хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	-	-	(19,465,527)	-	-	(19,465,527)
Дахин үнэлгээний нөөцийн хэрэгжсэн дүн	-	-	(4,965,138)	-	4,965,138	-
2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	28,614,263	2,927,696	28,362,014	13,799	24,344,457	84,262,229

Хуудас 13-51-д харуулсан тодруулгууд нь энэхүү тусдаа өмчийн өөрчлөлтийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

"Ард санхүүгийн нэгдэл" ХК
Тусдаа санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2023 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

Тусдаа мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2023 он	2022 он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн		3,765,932	3,778,396
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		3,765,932	3,778,396
Мөнгөн зарлагын дүн		(11,060,261)	(8,401,355)
Ажиллагчдад төлсөн		(1,315,769)	(1,129,475)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		(285,588)	(228,277)
Бараа материал худалдан авахад төлсөн		(58,544)	(7,670)
Ашиглалтын зардалд төлсөн		(86,183)	(82,169)
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		(92,262)	(165,099)
Хүүний төлбөрт төлсөн		(3,382,656)	(1,734,366)
Татварын байгууллагад төлсөн		(779,878)	(1,016,971)
Даатгалын төлбөрт төлсөн		(29,835)	(42,031)
Бусад мөнгөн зарлага		(5,029,546)	(3,995,297)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(7,294,329)	(4,622,959)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн		54,448,604	23,441,530
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		505,881	7,518,941
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		52,830,278	15,864,339
Хүлээн авсан хүүний орлого		1,067,551	15,948
Хүлээн авсан ногдол ашиг		44,894	42,302
Мөнгөн зарлагын дүн		(56,662,658)	(15,535,997)
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		(33,948)	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		(15,540,791)	(353,807)
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		(41,087,919)	(15,182,190)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(2,214,054)	7,905,533

"Ард санхүүгийн нэгдэл" ХК
Тусдаа санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2023 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

Тусдаа мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	Тодруулга	2023 он	2022 он
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн		13,939,021	9,805,111
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		13,939,021	9,805,111
Мөнгөн зарлагын дүн		(4,105,753)	(13,414,490)
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		(4,061,364)	(11,293,169)
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		-	(979,548)
Төлсөн ногдол ашиг		(44,389)	(1,141,773)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		9,833,268	(3,609,379)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ			
		324,885	(326,805)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7	3,917	330,722
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7	328,802	3,917

Хуудас 13-51-д харуулсан тодруулгууд нь энэхүү тусдаа мөнгөн гүйлгээний тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Тайлбар толь

Хувьцаа эзэмшигч	Өөрчлөлт, тоо
ХК	Хувьцаат Компани
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
ББСБ	Банк Бус Санхүүгийн Байгууллага
ХЗХ	Хадгаламж Зээлийн Хоршоо
ҮЦК	Үнэт Цаасны Компани
УБҮЦБ	Улаанбаатар Үнэт Цаасны Бирж эсвэл Ulaanbaatar Exchange буюу UBX
AARD	Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаа
AIC	Ард Даатгал ХК-ийн хувьцаа
ADB	Ард Кредит ХК-ийн хувьцаа
ХОС	Үндэсний Хувьчлалын сангийн нэгж эрх
CNF	Крипто Үндэстэн ХК-ийн хувьцаа
MNP	Монгол шуудан ХК-ийн хувьцаа
TNGR	ТэнГэрЛиг Медиа Нэгдэл ХК-ийн хувьцаа
MOST	МОСТ Финтек ХК-ийн хувьцаа
ХОУС	Хөрөнгө Оруулагч Үндэстэн сангийн нэгж эрх
ARDT	Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцааны токенжуулсан хэлбэр
CupCake	Худалдан авалтын хариултаа хадгалах үйлчилгээ
Pick n Pay	Ардын харилцагчид хүссэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүүгүй, шимтгэлгүй хуваан төлөх
Ардын Эрх	Оноо цуглуулан, АрдКойн руу хөрвүүлэн авах урамшуулалт хөтөлбөр
Ард Апп	Санхүүгийн цогц үйлчилгээг агуулсан, лайф-стайл супер апп
АрдКидс	Хүүхдийн анхны санхүүгийн апп
YoY	Year-on-year буюу өмнөх жилийн мөн үеэс хэрхэн өөрчлөгдсөнийг илэрхийлнэ
YTD	Year-to-date буюу оны эхнээс хэрхэн өөрчлөгдсөнийг илэрхийлнэ
CAGR	Compound annual growth rate буюу нийлмэл жилийн дундаж өсөлт

30
ЖИЛ
ARD

ҮНДЭСНИЙ ДААТГАГЧ АРД ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИ ҮҮСГЭН
БАЙГУУЛАГДСАНЫ 30 ЖИЛИЙН ОЙН МЭНДИЙГ ХАРИЛЦАГЧ, ДААТГУУЛАГЧ,
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ҮЕ ҮЕИЙН АЖИЛЛАГСАД ТА БҮХЭНДЭЭ ХҮРГЭЭ

АМАР ТАЙВАН АМЬДРАЛД ХӨТЛӨХ
АРД ДААТГАЛ **ТАНЫ ДААТГАЛ**

Хүчтэй. Хамтдаа.